



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД 2019 ОНД ОРУУЛСАН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ДАГУУ ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН
ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, БҮРЭН ЭРХИЙН
ХАРЬЦУУЛАЛТ БОЛОН ГАДААД, ДОТООДЫН ЭРДЭМТЭН
СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ**

Улаанбаатар хот

2022 он

ТАЛАРХАЛ

“Энэхүү бүтээлийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль болон Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн багш, судлаач оюутнуудын баг хийж гүйцэтгэв. Судалгааны ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн байгууллагуудад талархал илэрхийлье. Бүтээлд илэрхийлэгдсэн агуулга, дүгнэлт, санал нь судлаачдын үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.”

Судалгааны багийн бүрэлдэхүүн

Судалгааны багийн ахлагч:

О. Алтантуяа \МУИС - Хууль Зүйн Сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн багш\
Д. Бадамдаш \МУИС - Улс төр судлалын тэнхимийн багш\

Төслийн зохицуулагч:

Р. Оюундэлгэр \Төслийн зохицуулагч, судлаач, МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\

Судалгааны багийн гишүүд:

Ү. Ананд \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\
Б. Баасансүрэн \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\
Г. Баярчимэг \МУИС - Улс төр судлалын магистрант\
О. Одчимэг \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\
Б. Сарантуяа \МУИС - Улс төр судлалын магистрант\
Д. Сайнбаяр \МУИС - Улс төр судлалын тэнхим, IV түвшин\
Б. Тэлгүн \МУИС - Хууль Зүйн Сургууль, III түвшин\
Э.Энхмаа \МУИС - Улс төр судлалын тэнхим, IV түвшин\
Э.Эрхбилгүүн \МУИС - Хууль Зүйн Сургууль, V түвшин\

ОРШИЛ

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Улс төр судлалын тэнхимийн багш, судлаач оюутнуудын баг Монгол улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн дүн шинжилгээ”, “Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн үйл явц, төлөв”, “Монгол улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинээр байгуулагдсан засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийн харьцуулалт болон гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын байр суурь”, гэсэн 3 төрлийн судалгааг хийж, тайлан бэлтгэн хүргэж байна. “Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн дүн шинжилгээ” судалгааны хүрээнд Үндсэн хуулийн үзэл баримтлал, нэмэлт, өөрчлөлт хийх хэрэгцээ, шаардлага, ач холбогдол зэргийг, “Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэхээр батлах хууль тогтоомжийн үйл явц, төлөв” судалгааны хүрээнд Улсын их хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсантай холбоотойгоор бусад хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга, өргөн баригдсан хуулийн төслийн төлөв байдал, хэрэгжилт зэргийг, гуравдах буюу энэхүү судалгаагаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө засгийн газрыг хэрхэн байгуулж байсан тухай болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дараагаар засгийн газрыг байгуулсан үл явцын талаар тус тус харьцуулан судаллаа. Мөн энэхүү судалгааны хоёрдугаар хэсэгт Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар дотоодын болон гадаадын эрдэмтэн, судлаачид ямар байр суурьтай байгаа талаар тэдгээрийн бичсэн, нийтэлсэн судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл зэргийг судлан та бүхэнд хүргэж байна.

СУДАЛГААНЫ АГУУЛГА

1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРУУД /2019 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨӨС ӨМНӨХ/	5
ОРШИЛ.....	5
1.1. ОНОЛЫН ОЙЛГОЛТ	5
1.2. 1992 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗРЫГ ЭМХЛЭН БАЙГУУЛАХ, ОГЦРУУЛАХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН НЬ	6
1.3. 2000 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТӨӨР ЗАСГИЙН ГАЗРЫГ ЭМХЛЭН БАЙГУУЛАХ, ОГЦРУУЛАХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН НЬ.....	7
1.4. МОНГОЛ УЛСЫН ҮЕ ҮЕИЙН ЗАСГИЙН ГАЗАР	9
1.5. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН СТАТУС.....	12
1.6. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....	12
ДҮГНЭЛТ	14
2. 2020 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ДАРАА ЗАСГИЙН ГАЗРЫГ БАЙГУУЛСАН ТУХАЙ	14
ОРШИЛ.....	14
2.1. ОНОЛЫН ОЙЛГОЛТ	14
2.2. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	21
2.3. 2020 ОНЫ СОНГУУЛИЙН ДАРААХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН.....	26
ДҮГНЭЛТ	28
3. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 2019 ОНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ	29
ОРШИЛ.....	29
3.1. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 2019 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ДОТООДЫН ЭРДЭМТДИЙН БАЙР СУУРЬ.....	29
УЛС ТӨРИЙН АГУУЛГА БҮХИЙ.....	29
ЭРХ ЗҮЙН АГУУЛГА БҮХИЙ.....	40
3.2. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 2019 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЭРДЭМТДИЙН БАЙР СУУРЬ	63
ДҮГНЭЛТ	75
ЭХ СУРВАЛЖ.....	76
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	79

1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРУУД /2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс өмнөх/

ОРШИЛ

Манай улсын хувьд 1992 оны долдугаар сарын 21-нд байгуулагдсан П.Жасрай Ерөнхий сайдын тэргүүлсэн засгийн газраас тоолбол 2022 оны гуравдугаар сарын 12 хүртэлх хугацаанд нийт 14 ерөнхий сайдын тэргүүлсэн засгийн газар ажиллаж байсан.¹ Эдгээрээс ердөө хоёр нь үндсэн хуулийн дөчдүгээр зүйлийн 40.1-т “засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна” хэмээн заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлсэн бөгөөд нэг засгийн газрын бүрэн эрхээ хэрэгжүүлсэн дундаж хугацаа 2 жил байна. Энэхүү судалгаанд 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хүртэлх хугацаанд засгийн газрыг хэрхэн эмхлэн байгуулж ирсэн түүнтэй холбоотой хууль, эрх зүйн өөрчлөлтүүдийн талаар судалж, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

1.1. Онолын ойлголт

Монгол Улсын анхны Засгийн газар 1921 оны ардын хувьсгалын дараа “Ардын түр засгийн газар” нэртэйгээр МАХН-ын Төв хорооны өргөтгөсөн хурлаар байгуулагджээ. Энэхүү Засгийн газар нь 1924 он хүртэл төрийн эрх барих, гүйцэтгэн захирамжлах, шүүн таслах дээд эрхийг нэгэн зэрэг хэрэгжүүлж байв. 1924 оны Үндсэн хуулиар Засгийн газрыг тус улсын ерөнхийлөн захирах газар гэж тодорхойлоод, Улсын Бага Хурлын чөлөө цагт улсын дээд эрхийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчидтэй хамтран хэрэгжүүлэх газар байхаар зохицуулжээ. 1932 онд ардын Засгийн газрыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл хэмээн нэрлэх болсон бөгөөд энэ нь тус улсын гүйцэтгэн захирах дээд байгууллага байжээ. 1990 онд батлагдсан 1960 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулиар Сайд нарын зөвлөлийг Засгийн газар гэж нэрлэх болсон нь шинэ Үндсэн хуульд тусгалаа олсон бөгөөд 38.1 дэх хэсэгт “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” хэмээн заажээ. Ийнхүү Засгийн газрын мөн чанар өөрчлөгдөж, гүйцэтгэн захирамжлах дээд байгууллагаас танхимын зарчмаар ажилладаг гүйцэтгэх дээд байгууллага болсон юм.²

Ардчилсан улсын төрийн тогтолцооны онцлог нь эрх мэдэл хуваарилах зарчимд тулгуурлан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдлыг бий болгохын зэрэгцээ уялдаа холбоог хангаж, улмаар үр дүнтэй төрийн байгууллын механизм бүрдүүлж чаддагт оршино. Ингэснээр нийгэм-эдийн засгийн шинэтгэл хэрэгжих үндэс болсон төрийн бодлогын тогтвортой байдал хангагддаг байна. Энэ жишиг ёсоор Монгол улс төрийн ардчилсан тогтолцоонд шилжиж, 1990 оноос өнөөг хүртэлх хугацаанд улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээг хамарсан олон чухал өөрчлөлтийг хэрэгжүүлсээр ирсэн. 1992 онд батлагдсан 6 бүлэг, 70 зүйл бүхий шинэ үндсэн хууль, түүнд нийцүүлж гаргасан бусад салбар хуулийн дагуу төрийн байгууллагын бүтэц, тэдгээрийн эрх мэдэл, үйл ажиллагаа, чиг үүргийн харьцааг тогтоож, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг бүрэлдүүлэх чиглэлд багагүй ажил хийсэн байна. Ерөнхий агуулгын хувьд үндсэн хууль нь төрийн байгууллагын эрх мэдлийн хуваарилалт, хяналтын тогтолцоог холимог засаглалын

¹ Л.Оюун-эрдэнийн тэргүүлсэн засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусах болоогүй бөгөөд тодорхойлох боломж хомс байгаа учир уг засгийн газрыг оролцуулалгүй 14 Засгийн газар гэж үзсэн болно.

² “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” УБ, 2016, 103 дахь тал <https://www.mn.undp.org/content/dam/mongolia/Publications/undsen%20huuлин%20sudalгаа.pdf>

хүрээнд хуульчилж тогтоосон байдгаараа онцлогтой юм. Нөгөө талаас манай улсад ардчилал хөгжсөнөөр олон намын тогтолцоо төлөвшиж, сонгуулийн үр дүнгээс хамааран засгийн газар солигдох нь хэвийн үзэгдэл болсон ч бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах асуудал юу юунаас илүү чухалчлагдаж байна. Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдлийн тогтолцоонд анхаарал татах хэд хэдэн асуудал байгаагийн нэг нь засгийн газар байгуулж, огцруулах үйл явцтай холбогдсон эрх зүйн зохицуулалт юм. Энэ хүрээнд эрх зүйн оновчтой зохицуулалт хийгдсэн байх нь өөрөө төрийн бодлогын тогтвортой байдалд эергээр нөлөөлдөг байна.³

1.2. 1992 оны Үндсэн хуулиар Засгийн газрыг эмхлэн байгуулах, огцруулах харилцааг зохицуулсан нь

1992 оны Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 33.1.2-т Ерөнхийлөгч нь Улсын Их Хуралд олонх суудал авсан намтай, аль нэг нам олонхын суудал аваагүй бол УИХ-д суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн засгийн газар огцруулах саналыг УИХ-д оруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, гучин есдүгээр зүйлийн 39.2-т Ерөнхий сайд танхимын бүтэц, бүрэлдэхүүний талаар саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө Ерөнхийлөгчтэй зөвшилцөнө гэсэн зохицуулалт байсан.⁴ Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдад нэр дэвшигчийг тодруулахад нөлөөтэй оролцох эрхтэй байсан учраас засгийн газрыг байгуулах, огцруулах асуудалд сөрөг үр дагаврууд гарч ирсэн. Учир нь, Ерөнхий сайдыг томилох, танхимыг бүрдүүлэх үйл явцын талаар Ерөнхийлөгч болон Улсын Их Хурал яг ямар бүрэн эрхтэй байхыг Үндсэн хуульд нарийвчлан тусгаагүй тул УИХ болон Ерөнхийлөгч нь ерөнхий сайдад нэр дэвшигчийн талаар мөн танхимыг бүрдүүлэх үед санал зөрөлдвөл яаж зохицуулах нь тодорхой биш⁵ байжээ. Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад заасан үйл явц эхнээсээ дахин явагдах бөгөөд томилгооны асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй УИХ хариуцлага хүлээх эсэх талаар тодорхой зохицуулалт байхгүй байсан. 1992 оны Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт “Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно” гэж зохицуулсан. Энэ заалтын дагуу Ерөнхий сайд танхимдаа ажиллах сайдын талаар санал гаргах эрхтэй, томилох, чөлөөлөх, огцруулах эрхгүй байсан. Мөн 1992 оны Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах санал гаргавал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэхээр, дөчин дөрөвдүгээр зүйлд зааснаар Засгийн газарт өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхтэй холбоотой харилцааг тус тус зохицуулж ирсэн. Энэхүү зохицуулалтын дагуу УИХ-ын 19 ба түүнээс дээш гишүүн Засгийн газрыг огцруулах санал гаргах боломжийг олгож, хэд хэдэн нам УИХ-д суудалтай эсхүл олонх цөөнхийн харилцаа ойролцоо байгаа тохиолдолд засгийн газрын тогтворгүй байдлыг үүсгэж байсан. Энэ нь 2000 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах гол шалтгааны нэг болсон.

³ Н.Отгонбаяр “Засгийн газрыг байгуулж, огцруулах, эрх зүйн зохицуулалт, төрийн бодлогын тогтвортой байдалд үзүүлэх нөлөө”, УБ, 2017, 2 дахь тал

⁴ “Хууль дээдлэх ёс” Хууль зүйн эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүл цуврал 4/84/ 163 дахь тал

⁵ Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ, УБ, 2015, 22 дахь тал

1.3. 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрыг эмхлэн байгуулах, огцруулах харилцааг зохицуулсан нь

Төрийн бодлогын залгамж чанарыг, сайжруулах, жил бүр засгийн газар солигддог нөхцөл байдлыг зохицуулах, засаглалын тогтвортой байдлыг хангах зорилгоор Улсын Их Хуралд суудал бүхий гурван намын дэмжлэгтэйгээр 1999 оны 12 дугаар сарын 24-д Монгол Улсын Үндсэн хульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг нэмэлт өөрчлөлтийг тухайн үед МАХН дэмжсэн ч Ерөнхийлөгч Н.Багабанди хориг тавьсан. Гэсэн ч Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хүлээж авалгүйгээр нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор нэр бүхий нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргаж, Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг санаачлахдаа Үндсэн хуулийн цэц болон Ерөнхийлөгчтэй зөвшилцөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 1.2, жаран наймдугаар зүйлийн 68.1, далдугаар зүйлийн 70.1 дэх хэсгийг тус тус зөрчиж байна гэж үзэж тус нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгосон. Гэвч 2000 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан парламент 2000 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 1999 оны нэмэлт, өөрчлөлтийг яг тэр хувилбараар нь дахин баталсан. Ерөнхийлөгч Н.Багабанди дахин хориг тавьсан боловч Улсын Их Хурал хоригийг хүлээж аваагүй. Эцсийн дүнд, 2001 онд улс төрийн идэвхтэй зөвшилцөл явагдсаны дараа нэмэлт, өөрчлөлтийг Ерөнхийлөгч хүлээн авч, Үндсэн Хуулийн Цэц эсэргүүцээгүй байна.⁶

№	Зүйл заалт	1992 оны Үндсэн хуулийн заалт	2000 оны нэмэлт, өөрчлөлт
1	33.1.2	Улсын Их Хуралд олонх суудал авсан намтай, аль ч нам олонхын суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулах	УИХ-д олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг, аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам эвсэлтэй зөвшилцөж ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор УИХ-д оруулах зохицуулалт.
2	39.2	Монгол улсын ерөнхий сайд засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ	Ерөнхий сайд уул асуудлыг ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадахгүй бол УИХ-д өөрөө өргөн мэдүүлнэ.

⁶ Мөн тэнд

Хүснэгт 1. 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Ерөнхий сайдын томилгоо

Дээрх өөрчлөлтүүд нь Ерөнхийлөгчийн зөвшилцөх бүрэн эрхийг хасаж, УИХ дахь олонх Ерөнхий сайдад нэр дэвшүүлсэн хүнээ Ерөнхийлөгчөөр дамжуулан УИХ-руу оруулах боломжийг нээсэн ба Ерөнхийлөгчийн үзэмжээрээ ханддаг байдлыг зогсоож, Ерөнхийлөгчийн томилгооны эрх нь үүрэг болон хувирсан. Энэ заалтад ерөнхий сайдад нэр дэвшигчийг гурван янзаар тодруулж болохоор заасан бөгөөд эхний хоёр нь практикт хэрэгжсэн бол сүүлийнх нь одоогоор хэрэгжээгүй байна.⁷

Санал хураалтын босго:

№	Зүйл, заалт	1992 оны Үндсэн хуулийн заалт	2000 оны нэмэлт өөрчилөлт
1	27.6	Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонх нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд тооцож, чуулганд оролцсон нийт гишүүний олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ	УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлаа саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ

Хүснэгт 2. 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 27.6

Ирцийн доод хязгаар тогтоохын ач холбогдол нь аливаа шийдвэр гаргахад төлөөллийн байгууллагын хүрэлцэхүйц олон гишүүд оролцох журмыг хангахад оршино.⁸ 2000 онд Улсын Их Хурал дахь олонх ирцээ бүрдүүлж шийдвэр гаргах боломж олгох үүднээс Үндсэн хуулийн 27.6-г “УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлаа саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ” гэж өөрчлөн найруулсан. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц хүчинтэйд тооцогдох, нууц санал хураалтыг илээр явуулахаар болсон нь ямар ч асуудлыг ердийн олонхоор амархан шийдвэрлэх, засгийн газрыг огцруулах эсэх чухал асуудлыг ердийн олонхын саналаар шийдвэрлэх боломжтой болсон байна.

⁷ О.Мөнхсайхан, Засгийн газрыг эмхлэн байгуулах ажиллагаа: Kongrad Adenauer Stiftung, Төрийн байгуулал судлал сэтгүүл, УБ, 2018, 48 дахь тал

⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, “Эрх зүйн боловсрол академи” УБ, 2009, 139 дэх тал

1.4. Монгол Улсын үе үеийн засгийн газар

№	Байгуулагдсан , бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон огноо	Ерөнхий сайдууд	Улс төрийн намын харьяалал ба засгийн газрын хэлбэр	Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох шалтгаан	Бүрэн эрхийн үргэлжилсэн хугацаа
1	1992.07.21-1996.07.19	П. Жасрай	МАХН дангаараа	УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон	4 жил
2	1996.07.19-1998.04.23	М. Энхсайхан	МУАН, МСДН-ын Ардчилсан Холбоо эвсэл	Намын дарга ерөнхий сайд байх ёстой гэсэн байр сууринаас сайн дураараа огцорсон.	1 жил 9 сар
3	1998.04.23-1998.12.09	Ц. Элбэгдорж	МУАН, МСДН-ын Ардчилсан Холбоо эвсэл	Төрийн өмчийн “Сэргээн босголт” банкийг хувийн өмчийн “Голомт” банкттай нэгтгэсэн 1998 оны тавдугаар сарын 27-ний өдрийн Засгийн гарзын 80 дугаар тогтоол хууль бус гэсэн үндэслэлээр УИХ-ын 26 гишүүн огцруулах хүсэлт гаргасан.	8 сар
4	1998.12.09-1999.07.22	Ж. Наранцацралт	МУАН, МСДН-ын Ардчилсан Холбоо эвсэл	ОХУ-ын ерөнхий сайдын нэгдүгээр орлогч Ю. Д. Маслюковт илгээсэн Зарубежцветмет нэгдлийн хувьчлалтай холбоотой захидал үндэсний эрх ашигт хохирол учруулсан гэж үзэн УИХ-ын 21 гишүүн огцруулах хүсэлт гаргасан.	1 жил
5	1999.07.30-2000.07.26	Р. Амаржаргал	МУАН, МСДН-ын Ардчилсан Холбоо эвсэл	УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон	1 жил

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой судалгааны тайлан - III

6	2000.07.26- 2004.08.20	Н. Энхбаяр	МАХН дангаараа	УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон	4 жил 1 сар
7	2004.08.20- 2006.01.13	Ц. Элбэгдорж	МАХН, МАН-ын эвсэл	МАХН-ын Удирдах Зөвлөлийн 2006 оны нэгдүгээр сарын 11-нд гаргасан шийдвэрийн дагуу Засгийн газрын 10 сайд огцрох хүсэлт гаргасан.	1 жил 5 сар
8	2006.01.26- 2007.11.07	М. Энхболд	МАХН, БНН, Эх орон нам, Шударга ёсны нам	Намын дарга ерөнхий сайд байх ёстой гэсэн байр сууринаас өөрөө хүсэлт гаргаж чөлөөлөгдсөн.	1 жил 10 сар
9	2007.11.22- 2009.10.29	С. Баяр	МАХН, ИЗН, Шударга ёсны нам	Эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн	1 жил 11 сар
10	2009.10.29- 2012.08.10	С. Батболд	МАХН, ИЗН, Шударга ёсны нам	УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон	2 жил 10 сар
11	2012.08.10- 2014.11.05	Н. Алтанхуяг	МАХН, ИЗН, МҮАН	Улсын эдийн засгийг хүнд байдалд оруулсан гэх үндэслэлээр УИХ-ын 28 гишүүн огцруулах хүсэлт гаргасан.	2 жил 2 сар
12	2014.11.21- 2016.07.8	Ч. Сайханбилэг	МАХН, ИЗН, МҮАН	УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон	1 жил 7 сар
13	2016.07.08- 2017.10.04	Ж. Эрдэнэбат	МАН дангаараа	УИХ-ын 31 гишүүн засгийн газрыг огцруулах хүсэлт гаргасан.	1 жил 3 сар
14	2017.09.08- 2021.01.27	У.Хүрэлсүх	МАН дангаараа	Огцрох хүсэлтээ гаргасан.	3 жил 5 сар

Хүснэгт 3. Үндсэн хууль батлагдсанаас хойш байгуулагдсан засгийн газрууд⁹

Дээрх хүснэгтээс харвал, бүрэн эрхээ дуусгасан хоёрхон Засгийн газар байсан бөгөөд бусад Засгийн газрууд хугацаанаас өмнө огцорч байжээ. Нэг парламентын бүрэн эрхийн хугацаанд дөрвөн Засгийн газар солигдож байсан тохиолдол ч гарч байгааг харж болно.

Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн төрийн захиргааны албадыг эмхлэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, бүтэц, чиг үүргийг тодорхойлох, төрийн захиргааны мэргэшсэн албыг бүрдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын тухай хууль 1993 онд, Төрийн албаны тухай хууль 1994 онд батлагдан гарсан. Үүнээс нэлээд хожим 2004 онд Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль тус тус батлагдсан юм. Төрийн захиргааны төв байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт Засгийн газар солигдохтой хамт өөрчлөгдөж ирсэн. Яамдыг салгах, нийлүүлэх, шинээр байгуулах, татан буулгах, 108 нэршлийг нь солих, агентлагийн харьяаллыг өөрчлөх нь аль ч Засгийн газрын үед түгээмэл байсан. Үүнийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилттой уялдуулж байна гэж үе үеийн Засгийн газар тайлбарладаг. Гэхдээ уг өөрчлөлтийг хийхдээ эдийн засгийн тооцоо судалгаа, чиг үүргийн шинжилгээ хийх, салбар дундын зохицуулалтыг хэрхэн сайжруулах, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын саналыг авах, төсвийн ачааллыг багасгах гэх мэт тодорхой үндэслэл байдаггүй. Зарим тохиолдолд яамдын тоог нэмэгдүүлэх нь сонгуульд ялсан болон эвсэлд нэгдсэн намын гишүүд, дэмжигчдийг сайдын албан тушаалтай болгоход чиглэгддэг гэсэн шүүмжлэлд өртөж байв.¹⁰

Засгийн газрын үндсэн бүтцийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал

Байгууллага/он	1992	1996	2000	2004	2008	2012	2016
Яам	16	9	11	13	11	16	13
Засгийн газрын тохируулагч агентлаг	–	22	17	14	12	11	10
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг	-	37	31	23	31	17	17
Агентлагийн нэгдсэн тоо	-	59	48	37	43	28	27
Нийт яам, агентлагийн тоо	16	68	59	50	54	44	40

Хүснэгт 4. Засгийн газрын үндсэн бүтцийн өөрчлөлт 1992-2016 он

⁹ pp

¹⁰ Мөн тэнд

1.5. Үүрэг гүйцэтгэгчийн статус

1992 оноос өдийг хүртэл Үүрэг гүйцэтгэгч Ерөнхий сайдын хоёр тохиолдол байдаг. 1999 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс 7 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх найман өдрийн турш Үүрэг гүйцэтгэгч Ерөнхий сайдаар Н.Туяа ажиллаж байсан мөн 2014 оны 10 дугаар сараас 11 сар хүртэл Д.Тэрбишдагва сарын турш Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэсэн байдаг. Засгийн газрын тухай хуулийн хорин нэгийн 21.6 дахь хэсэгт “Ерөнхий сайдын бүрэн эрх биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсны улмаас чөлөөлөгдсөн, нас нөгчсөн үндэслэлээр хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Шадар сайд гүйцэтгэнэ” хэмээн заасан байдаг.

1.6. Харьцуулсан судалгаа

Холбооны Бүгд Найрамдах Герман улс

Холбооны канцлерыг Бундестагт шүүн хэлэлцүүлэхгүйгээр Холбооны ерөнхийлөгчийн санал болгосны дагуу санал хураалтаар сонгоно. Бундестагийн гишүүдийн олонхын санал авсан хүнийг сонгогдсонд тооцно. Сонгогдсон нэр дэвшигчийг холбооны ерөнхийлөгч батална.

Испани улс

Эзэн хаан дараах бүрэн эрхтэй;

- Засгийн газрын тэргүүнд нэр дэвшигчийг санал болгох, шаардлагатай тохиолдолд үндсэн хуульд заасан нөхцөлөөр албан тушаалд нь томилох, чөлөөлөх,
- Засгийн газрын тэргүүний санал болгосноор засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх
- Конгресс шинээр бүрдэх бүрд, эсхүл үндсэн хуульд заасан тохиолдолд эзэн хаан парламент дахь улс төрийн намуудын төлөөлөлтэй урьдчилан зөвшилцсөний эцэст Конгрессын даргаар уламжлан ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигчийг тодруулна.
- Өмнөх зүйлд заасны дагуу гаргасан засгийн газрын тэргүүнд нэр дэвшигч нь танхимаас өөрт нь итгэл үзүүлэх эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэж, засгийн газрын улс төрийн хөтөлбөрөө Конгресс-д танилцуулна.
- Конгресс-д гишүүдийн үнэмлэхүй олонхын саналаар итгэл үзүүлбэл эзэн хаан нэр дэвшигчийг ерөнхий сайдаар томилно. Хэрэв үнэмлэхүй олонхын санал авч чадаагүй бол 48 цагийн дотор шинээр санал хураалгах ба ийнхүү санал хураахад энгийн олонхын санал авсан бол итгэл үзүүлсэн гэж үзнэ.
- Хэрэв дахин санал хураалтаар итгэл үзүүлээгүй бол өмнөх зүйлд заасан журмаар шинэ санал оруулна.
- Засгийн газрын гишүүнд томилох эхний санал хураалтаас хойших хоёр сарын хугацаанд нэр дэвшигчдийн нэг нь ч итгэл хүлээгээгүй бол эзэн хаан хоёр танхимыг тарааж, конгрессын даргатай зөвшилцөн шинэ сонгууль товлон зарлана.
- Засгийн газрын тэргүүний санал болгосноор эзэн хаан засгийн газрын бусад гишүүдийг томилж, чөлөөлнө.
- Бүх нийтийн сонгууль явагдсаны дараа, үндсэн хуульд заасан нөхцөлөөр парламентын зүгээс итгэл үзүүлээгүй бол, тэрчлэн тэргүүн огцорсон, нас барсан тохиолдолд засгийн газар огцорно.

Солонгос улс

Ерөнхий сайдыг ерөнхийлөгч Үндэсний Хуралтай зөвшилцөн томилно. Төрийн Зөвлөлийн гишүүдийг ерөнхий сайдын санал болгосноор ерөнхийлөгч томилно. Төрийн Зөвлөлийн аль нэг гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх хүсэлтийг ерөнхий сайдын зүгээс ерөнхийлөгчид өргөн барьж болно. Төрийн Зөвлөл нь ерөнхийлөгч, ерөнхий сайд, гучаас багагүй, тавиас ихгүй тооны бусад гишүүдээс бүрдэнэ. Төрийн Зөвлөлийн дарга нь ерөнхийлөгч, орлогч дарга нь ерөнхий сайд байна.

№	Улсын нэр, Үндсэн хууль батлагдсан он	Засаглалын хэлбэр	Ерөнхий сайдын нийт тоо	Ерөнхий сайдын бүрэн эрхийн хугацааны дундаж /жил/
1	Герман 1949	Парламентын	9	8.1
2	Ирланд 1937	Хагас ерөнхийлөгчийн	13	6.5
3	Финланд 1999	Хагас ерөнхийлөгчийн	7	3.1
4	Бельги 1970	Парламентын	11	4.4
5	Португали 1976	Хагас ерөнхийлөгчийн	16	2.7
6	Швед 1974	Парламентын	12	4.9
7	Чех 1993	Хагас ерөнхийлөгчийн	12	2
8	Болгар 1991	Хагас ерөнхийлөгчийн	14	1.8
9	Румын 1991	Хагас ерөнхийлөгчийн	11	2.3
10	Испани 1977	Парламентын	7	6.3
11	Монгол 1992	Парламентын	14	2

Хүснэгт 5. Засгийн газрын тогтвортой байдал: Ерөнхий сайдын бүрэн эрхийн хугацааны дундаж

ДҮГНЭЛТ

Төрийн бодлогын залгамж чанарыг хангах, хуулиар олгогдсон гүйцэтгэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд засгийн газар тогтвортой оршин байх шаардлагатай болно. Нөгөө талаас засгийн газарт бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж олгохын зэрэгцээ хяналт, хариуцлагын зарчмыг хамтад нь нэвтрүүлэх шаардлага байгааг харуулж байна. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг үр бүтээлтэй ажиллуулахын зэрэгцээ хууль тогтоох байгууллагын хяналтад байлгах хамгийн үр дүнтэй арга нь засгийн газрын гишүүдийн тодорхой хэсэг парламентын гишүүн байхыг зөвшөөрөх эрх зүйн зохицуулалт юм.

2. 2020 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ДАРАА ЗАСГИЙН ГАЗРЫГ БАЙГУУЛСАН ТУХАЙ

ОРШИЛ

Монгол Улсын Засгийн газар бол гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд байгууллага юм. Засгийн газрын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, түүний залгамж чанарыг хэрхэн сайжруулах тухай асуудалд шийдэл хайн 1992 оны Үндсэн хуульдаа 3 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулсан. 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 2000 онд Үндсэн хуульд оруулсан долоон нэмэлт, өөрчлөлтийн зургааг нь засан сайжруулсан бөгөөд Засгийн газрын бие даасан, танхимын зарчмыг бэхжүүлэх, гүйцэтгэх эрх мэдлийн томилгоонд оролцох Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын бүрэн эрхийг хумьж, засгийн газрын бүрэн эрхийг тодорхой болгоход чиглэсэн өөрчлөлтүүдийг тусгасан. Энэхүү судалгаандаа тэдгээрийн онолын ойлголт болоод Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт орсны дараа засгийн газар хэрхэн байгуулагдсан тухай судалж, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно.

2.1. Онолын ойлголт

- **Конструктив механизм**

Гүйцэтгэх эрх мэдлийн тогтвортой байх, тасралтгүй ажиллах, залгамж чанарыг хадгалахад конструктив механизм чухал үүрэгтэй байдаг. Конструктив механизм нь Засгийн газрыг огцруулж, шинэ ерөнхий сайдаар томилох нэр дэвшигч дээр улс төрийн зөвшилцөлд заавал хүрэхийг шаардсан онцлог бүхий механизм юм.¹¹ Нэг ёсондоо одоогийн Засгийн газрыг огцруулах болоод шинэ ерөнхий сайдыг томилох асуудлыг нэгэн зэрэг шийднэ гэсэн үг юм. Конструктив механизм нь ойрхон давтамжтай засгийн газрыг огцруулах, хуучин ба шинэ Ерөнхий сайдын хооронд сонголт хийх боломжийг хурдасгаж, Засгийн газрыг парламентаас хараат болгох боломжийг хязгаарладаг. ХБНГУ-ын Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд “Бундестаг, Бундесканцлерт итгэл үзүүлэх тухай асуудлыг хэлэлцэж болох бөгөөд ингэхдээ гишүүдийн олонхын саналаар Бундесканцлерын залгамжлагчийг урьдчилан сонгож, нэрийг Ерөнхийлөгчид хадгалуулсны дараа Бундесканцлерыг чөлөөлнө”¹² хэмээн заасан байдаг. Энэхүү заалт нь засгийн газрыг огцруулахын тулд оронд нь томилогдох нэр дэвшигч дээр тохиролцоо хийхийг шаардаж байгаа нь засгийн газрыг огцруулах

¹¹ О.Машбат, Үндсэн хууль: Улс төр-эрх зүй, хяналт-тэнцэл, 2015, 118-119 дэх тал

¹² Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль 67 дугаар зүйл, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>, 54 дэх тал

эрсдэлийг бууруулж байна. Засгийн газрын тогтвортой байдал нь төрийн бодлого тууштай хэрэгжих боломжийг олгодог. Харин Үндсэн хууль судлаач О.Машбатын үзсэнээр үүнд нэг сөрөг тал байгаа нь ерөнхий сайдын асуудлыг хөндөх бүрдээ парламент өөрөө тарах эрсдэлийг хүлээж байдаг тул ерөнхий сайдын дарангуйлал тогтох магадлалтай байдаг.¹³ Мөн өөр нэг сөрөг тал нь эвслийн засгийн газар байгуулагдахад ажиглагддаг бөгөөд гурав дахь хүчин засгийн газрын тогтворгүй байдлаар тоглолт хийх боломжийг үүсгэдэг.¹⁴ Дэлхийд Герман, Унгар, Польш, Израйл зэрэг арваад орон конструктив механизмыг ашигладаг бөгөөд өндөр хөгжилтэй бусад улсад энэхүү механизм байхгүй байгаа нь улс төрийн системийн тогтвортой байдал, намын төлөвшил зэрэг бусад хүчин зүйлстэй холбоотой.

Харьцуулсан судалгаа:

Парламентын болон хагас ерөнхийлөгчийн засаглалтай улсуудад Ерөнхий сайдыг огцруулахад ердийн олонхын, туйлын олонхын, конструктив санал хураалт гэсэн ялгаатай арга замыг Үндсэн хуулиудад тусгаж өгсөн байдаг.¹⁵

Улс орнууд	Шийдвэрлэх арга зам
Британи, Финлянд, Япон, Итали, Ирланд	<p>Ердийн олонх</p> <ul style="list-style-type: none"> - Британи, Финлянд, Ирланд бол маш урт хугацаанд ардчилсан дэглэмтэй байж, Засгийн газар тогтвортой байх соёл бүрдсэн. - Японд Засгийн газар нь тийм ч тогтвортой биш боловч төрийн албан хаагчдын тогтвортой, мэргэшсэн байдал нь гүйцэтгэх эрх мэдлийг тогтворжуулдаг. - Итали бол хамгийн тогтворгүй Засгийн газартай улс, Засгийн газрын дундаж нас нь 2.6 жил.
Швед, Португали, Бельги, Грек, Эстони, Словак, Чех, Румын, Литва, Болгар	<p>Туйлын олонх</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн биш, парламентын нийт гишүүний олонхын саналаар шийдвэрлэдэг.
Герман, Испани, Унгар, Польш, Словени, Израйл	<p>Конструктив зарчим</p> <ul style="list-style-type: none"> - Эдгээр улсад парламентын гишүүдийн туйлын олонх Засгийн газарт итгэл үл үзүүлэхийг дэмжсэн байх төдийгүй дараагийн Ерөнхий сайдыг сонгосон тохиолдолд өмнөх Ерөнхий сайд огцордог.

¹³ О.Машбат, “Засгийн газрын тогтвортой байдлыг хангах нь- Конструктив механизм нь Монголд тохиромжтой эсэх нь” мэтгэлцээн, 2017

¹⁴ Д.Бадамдаш, “Засгийн газрын тогтвортой байдлыг хангах нь: Конструктив механизм нь Монголд тохиромжтой эсэх нь” мэтгэлцээн, 2017

¹⁵ О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн амин сүнс (ЗГ,Шүүх) долоохон санал дутсанаас үгүй болох уу” нийтлэл, 2019 он

	<ul style="list-style-type: none"> - ХБНГУ-ын Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд “Бундестаг, Холбооны Канцлерт итгэл хүлээлгэх тухай асуудлыг хэлэлцэж болох бөгөөд ингэхдээ гишүүдийн олонхын саналаар Холбооны канцлерын залгамжлагчийг урьдчилан сонгож ,сонгож, нэрийг Ерөнхийлөгчид хадгалуулсны дараа Холбооны канцлерыг чөлөөлнө" гэж конструктив механизмыг хуульчилсан байдаг. - Унгарын Үндсэн хуулийн 39-А дугаар зүйлд “Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тухай саналыг мөн тушаалд оронд нь сонгох хүний нэрийн хамт парламентын гишүүдийн тавны нэгээс доошгүйн дэмжлэгээр бичгээр гаргана. Хэрэв парламентын гишүүдийн олонх итгэл үзүүлэхээс татгалзвал саналд нэр дэвшсэн хүнийг шууд Ерөнхий сайдаар сонгогдсонд тооцно.”
--	--

Хүснэгт 6. Дэлхийн улс орнуудын ерөнхий сайдыг огцуулах арга замын харьцуулалт

- **Парламентын гишүүн Засгийн газрын гишүүний ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэх тухай**

Төрийн эрх мэдэл хуваарилалтын онол нь Грек, Ром зэрэг эртний улсуудын сэтгэгчдээс эхлэн судалсан бөгөөд энэ үеийн гол төлөөлөгчид нь Платон (МЭӨ 428/427-МЭӨ 348/347), Аристотель (МЭӨ 323-322), Полибий (МЭӨ 200-120) зэрэг юм. Энэ үеийн философичдын үзэл санаагаар бол улс төрийн шийдвэр гэдэг бол хууль, дүрэм, журмын хэлбэрээр илэрч түүнийг хэрэгжүүлэх явдал захиргааны үүрэг гэж үзсэн. Эртний онол урсгалын эдгээр үзэл санааг цаашид хөгжүүлэн судалсаар төрийн философи ба төрийн онолын салбарууд бий болсон. Энэ үеийн онолчдын нэг Дж.Локк “Хууль тогтоох, хууль хэрэгжүүлэх засаглал байна” гэх үзлийг бий болгосон бөгөөд түүний энэхүү үзлийг Ш.Монтескье өргөжүүлэн, системтэй онолын үзэл баримтлалыг боловсруулсан байна. Ш.Монтескьегийн төрийн эрх мэдэл хуваарилах онолын дагуу төрийн эрх мэдэл нэг гарт төвлөрөхгүйгээр харилцан тэнцвэртэй байхын зэрэгцээ нэг нь нөгөөгийн ажилд хутгалдах ёсгүй гэж үздэг. Түүний энэхүү үзэл санаа нь 1787 оны АНУ-ын Үндсэн хуульд тусгалаа олж, хэрэгжсэн байдаг.

XX зуунд төрийн эрх мэдэл хуваарилах онолын хүрээнд гарсан нэг шинэ чиг хандлага бол хууль тогтоох байгууллагын гишүүн нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын удирдлагад ажиллах боломжийг үгүйсгэхгүй гэсэн үзэл баримтлал байсан бөгөөд улс орнууд үүнийг Үндсэн хуулиараа зохицуулж байсан. XX зууны хагасаас эхлэн хэлэлцэгч парламент буюу Вестминстерийн (Их Британийн) загвар болоод үйлдэгч парламент буюу Боннын (Германы) гэсэн парламентын хоёр төрөл загварын тухай хэлэлцүүлэг ихээхэн дэлгэрсэн. Хэлэлцэгч парламент нь хууль тогтоох институтэд олонх болж чадсан улс төрийн хүчин засгийн газраа бүрдүүлдэг нь парламент-засгийн газар өөр хоорондоо уусах үндсэн шалтгаан болдог бөгөөд энэхүү парламент нь засгийн газрын боловсруулсан баримт бичгийг богино хугацаанд хэлэлцэн баталж, дэмжлэг үзүүлэх үр ашигтай гэж үздэг. Харин үйлдэгч парламент нь дан ганц хэлэлцэх бус түүнд шүүмжлэлтэй хандаж, үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай бөгөөд парламент-засгийн газрын нэгдэл тодорхой хэмжээнд байх ч эрх мэдлийн сонгодог хуваарилалтыг алдагдуулж болохгүй гэж үздэг байна. Хариуцлагатай Засгийн

газрын тухай сонгодог онолоор бол бүх нийтээс сонгогдсон парламент нь гүйцэтгэх засаглалыг байгуулж, огцрохыг шийддэг тул Засгийн газарт парламентын зүгээс итгэл үзүүлэх нь ард түмний итгэл гэж үзэж болно. Судлаач В.Бэйжхот “сайд нар бол улс төрийн ажилд суралцсан байх бөгөөд энэхүү мэргэжлийг залуу байхдаа сурч, практик дадлага хийх хамгийн гол газар нь Английн төлөөлөгчдийн танхим байдаг бөгөөд энд л зөвхөн шаардлагатай ур чадвар, хандлагыг олж авдаг”¹⁶ гэж үзсэн байдаг. Харин орчин үед сайд нарыг парламент дотроосоо бус гаднаас сонгох нь илүү нарийн мэргэжлийн хүмүүсээс Засгийн газрыг бүрдүүлэх ач холбогдолтой гэж судлаачид үзсэн.

Харьцуулсан судалгаа:

Дэлхийн улс орнуудад Парламентын гишүүн Засгийн газрын гишүүнийг хавсран гүйцэтгэх тухай асуудлыг үндсэн хуульдаа тусгадаг бөгөөд тухайн улсын онцлог, төрийн удирдлагын хэлбэрээс шалтгаалан янз бүр байдаг. Парламентын гишүүний болон Засгийн газрын гишүүний албан тушаалыг давхар эрхлэх асуудлыг бусад орны туршлагаас харахад тухайн улсын парламентын нийт гишүүдийн тоо, парламентын танхимын тоог харгалздаг байна.¹⁷

Улс	Засаглалын хэлбэр	Хүн ам /сая/	1 гишүүний төлөөлөх хүн амын тоо/мянган хүн/	Парламентын танхимын тоо	Парламентын нэр, гишүүний тоо
Австрали	Парламентын засаглалтай Үндсэн хуульт Хаант улс	24,8	109734	2	Дээд танхим-76 Доод танхим-150
Их Британи	Парламентын засаглалтай Үндсэн хуульт Хаант улс	66,6	50122	2	Лордын танхим-670 Нийтийн танхим-659
Япон	Парламентын засаглалтай Үндсэн хуульт Хаант улс	127,3	176114	2	Төлөөлөгчдийн танхим- 480 Зөвлөхүүдийн танхим- 242
Дани	Парламентын засаглалтай Үндсэн хуульт Хаант улс	5,8	32894	1	Фолькетинг-175
ХБНГУ	Үндсэн хуульт Парламентын засаглалтай	82,3	112601	2	Бундестрат-69 Бундестаг- 662

¹⁶ П.Амаржаргал, Парламентаас албан тушаалтныг сонгох тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл, шалтгаан. Хууль дээдлэх ёс сэтгүүл. 2017 он, 29 дэх тал

¹⁷ Конрад-Аднауэр-Сан, Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа, 2018 он, 60-61 дэх тал

Сингапур	Парламентын БН нэгдмэл улс	5,8	61706	1	Парламент-94
Польш	Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай БНУ	38,1	68032	2	Сенат-100 Сейм-460

Хүснэгт 7. Парламентын гишүүн засгийн газрын гишүүний ажил, албан тушаал давхар эрхлэхийг зөвшөөрдөг зарим орны судалгаа

Парламентын гишүүн болон Засгийн газрын гишүүний ажил, албан тушаалыг давхар эрхлэхийг зөвшөөрсөн улс орнууд ихэвчлэн хоёр танхимтай, 200-аас дээш гишүүдтэй байна. Улс орнуудад Парламентын гишүүн Засгийн газрын гишүүний ажил, албан тушаалыг давхар хашиж байгаа асуудлыг танхимын тоо, гишүүдийн тоо, хүн амыг төлөөлж байгаа тооноос гадна тухайн улсын түүхэн онцлог шинжтэй мөн хамаатай байдаг.

Улс	Засаглалын хэлбэр	Хүн ам /сая/	1 гишүүний төлөөлөх хүн амын тоо/мянган хүн/	Парламентын танхим, гишүүний тоо	Үндсэн хуулийн зохицуулалт
Франц	Үндсэн хуульт хагас Ерөнхийлөгчийн засаглалтай БНУ	65,2	70550	2 танхимтай. Сенат- 348 Үндэсний ассамблей-577	23. Засгийн газрын гишүүний чиг үүрэг нь парламентын гишүүний мандаттай, улс үндэсний хэмжээний ажил мэргэжлийн төлөөлөх албан тушаалтай, төрийн аливаа албаны болон мэргэшлийн үйл ажиллагаатай хавсармал байж болохгүй.
Украин	Хагас Ерөнхийлөгчийн засаглалтай БНУ	44	97750	1 танхимтай. Парламент-450	78. Украины Ардын депутат нь өөр төлөөллийн мандаттай болон төрийн алба хашиж болохгүй.
Молдова	Парламентын БНУ	4	40000	1 танхимтай. Парламент-101	70.1. Гишүүний байр суурь нь үндсэн цалинтай ямар нэгэн бусад албан тушаал хашихтай нийцэхгүй.

Эстони	Парламентын БНУ	1,3	12935	1 танхимтай. Рийгикогу-101	63. Рийгикогугийн гишүүн нь төрийн ямар ч албан тушаалыг хашиж болохгүй.
Болгар	Парламентын БНУ	7,0	29300	1 танхимтай. Үндэсний ассамблей-240	68. Үндэсний төлөөлөгчид төрийн алба хаших эсвэл түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох нь хуулийн дагуу үндэсний төлөөлөгчдийн байр суурьд нийцэхгүй болно.

Хүснэгт 8. Парламентын гишүүн болон засгийн газрын гишүүний албан тушаалыг давхар эрхлэхийг хориглосон зарим улс орнууд

Засгийн газраа парламентаас бүрдүүлдэг зарим хагас-ерөнхийлөгчийн тогтолцоонд парламентын гишүүд засгийн газарт давхар ажиллахыг хориглодог. Тайван, Франц, Португал, зэрэг тогтолцоонд үндсэн хуулиараа хориглосон заалт байдаг. Дээрх хүснэгтэд байгаа орнуудын хувьд ихэвчлэн нэг танхимтай, 1 гишүүний төлөөлөх хүний тоо Болгар, Унгар, Эстони, Молдова улсынх 40000 ба түүнээс бага байна.

- **Танхимын зарчим**

Уламжлал ёсоор эзэн хаан төрийн тэргүүн бөгөөд засгийн газрын тэргүүн байсан. Төрийн хэргийг удирдахын тулд хаанд туслах үүрэг бүхий кабинет буюу өөр өөр салбарыг хариуцсан сайдууд ажилладаг байсан бөгөөд сайдыг “minister” гэсэн нэр томъёог хаанд үйлчилж, туслах гэсэн утгаар өгсөн. Кабинет “cabinet” гэдэг нь анх үүсэхдээ хаан өөрийнхөө зөвлөхүүдтэйгээ уулзаж, ярилцдаг жижиг өрөөг хэлдэг байсан ба яваандаа хааны зөвлөх сайдуудын дундаас бусад сайдуудаа тэргүүлэн, зааварчилдаг нэг сайд томилох болсон бөгөөд энэ нь Ерөнхий сайд болох үе байсан.¹⁸ Парламентын болон Ерөнхийлөгчийн тогтолцооны ялгаа нь засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээдэг эсэхэд оршино. Засгийн газар өөрийн ажлыг хангалттай сайн хийж чадахгүй байгаа гэж парламент үзээд засгийн газрыг огцруулах боломжтой бол парламентын тогтолцоо гэж үзнэ.

Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимид “Ерөнхий сайд бол сайд нараа удирдаж асуудлыг дангаараа (тухайн асуудлыг эрхэлсэн сайдтайгаа тохиролцон) шийдвэрлэдэг систем”¹⁹ хэмээн тайлбарласан байдаг. Засгийн газрын танхим бодлогын асуудлаар хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээх нь танхимын зарчмын гол шинж юм. Засгийн газрын хариуцлагыг онолын үүднээс хамтын хариуцлага болон салбарын сайдын хариуцлага гэж ангилж үзнэ.²⁰

Засгийн газрын хамтын хариуцлага хүлээх зарчим:

Хамтын хариуцлагын тогтолцоо нь засгийн газрын танхим институцийн хувьд хамтын хариуцлага хүлээж, огцордог механизм юм. Засгийн газар гаргасан шийдвэр, үйл ажиллагааныхаа төлөө УИХ-

¹⁸ Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, 2019 он

¹⁹ Б.Чимид, Ардчиллын аман түүх, <https://www.youtube.com/watch?v=ZbjpmWLO7M0>,

²⁰ Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, 2019 он

ын өмнө хамтын хариуцлага хүлээх нь кабинетын зарчимд хамаарна. Яамны сайдаар ажиллаж, засгийн газрын гишүүн болохыг зөвшөөрөх нь хамтын хариуцлагын зарчмыг зөвшөөрсөн гэсэн үг юм. Ийм засгийн газрын гишүүн салбарын үйл ажиллагааг удирдахдаа засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй.²¹ Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ зэрэг зохицуулалт нь Засгийн газар хамтын шийдвэр гаргаж, хамтын хариуцлага хүлээдэг болохыг батална.

Засгийн газрын гишүүн дангаар хариуцлага хүлээх зарчим:

Засгийн газрын гишүүдийн дийлэнх нь тодорхой салбарын яамыг тэргүүлдэг. Сайдын хувьд эрхэлсэн асуудал, салбар яамныхаа үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдлын хариуцлагыг сайд өөр дээрээ үүрч улс төрийн хариуцлага хүлээдэг. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.1 “Эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ”²² гэж хуульчилсан байдаг.

Харьцуулсан судалгаа:

Судалгаанд дэлхийн 30 орны Үндсэн хуульд Ерөнхий сайд болон Засгийн газрыг огцруулах талаар хэрхэн зохицуулсныг авч үзсэн болно.²³ Онолын хувьд засгийн газрын бүрэн эрх дуусгавар болно гэдэг нь нэгдүгээрт, хуульд заасан бүрэн эрхийн хугацаа дууссан, хоёрдугаарт, парламент засгийн газарт итгэл үзүүлээгүйгээс засгийн газар огцорсныг ойлгоно. Хууль зүйн шинжлэх ухаанд нийтлэг тогтсон жишгээр ерөнхий сайд болон засгийн газрын огцрох асуудлыг засгийн газарт итгэл үзүүлэх гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг байна.²⁴ Засгийн газрын огцрох үндэслэл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсныг хэлдэг.

Ерөнхий сайд огцорсноор засгийн газар огцрох нь улс төрийн хариуцлагын хамгийн сонгодог хэлбэр бөгөөд ерөнхий сайд өөрийн танхимыг бүрдүүлэх эрх мэдэлтэй, түүнийхээ төлөө хариуцлага хүлээх үүрэгтэй нь холбоотой. Судалгаанаас үзэхэд дэлхийн ихэнх улс оронд засгийн газрыг танхимын зарчмаар бүрдүүлсэн байх ба танхимын зарчим нь ерөнхий сайд засгийн газрыг удирдаж, ажлаа парламентын өмнө хариуцах, засгийн газрын бүрэн эрхийн хугацаа ерөнхий сайдын бүрэн эрх эхэлж, дуусгавар болохтой шууд хамааралтай байх, ерөнхий сайд бүрэлдэхүүнээ өөрөө сонгодог (ерөнхий сайдын саналаар засгийн газрыг бүрдүүлэх), ерөнхий сайд танхимын гишүүддээ ажил үүргээ хуваарилж хариуцуулдаг, танхимын гишүүнийхээ төлөө өөрөө хариуцаж, асуудлыг багаар хэлэлцэх боловч тус яамны сайдын хамтаар гаргадаг зэрэг нь танхимын зарчмыг илэрхийлдэг байна.²⁵

²¹ Мөн тэнд.

²² Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он

²³ Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, давлагаа, 2017 он

²⁴ Мөн тэнд.

²⁵ Мөн тэнд.

Засгийн газрын тэргүүн болон гишүүдийн огцруулах субъект	Улсын тоо	Улсын нэр
Парламент	13	БНХАУ, Болгар, Босни-Герцеговин, Их Британи, Латви, Итали, Чрна Гора, Серби, Словени, Унгар, Хорват, Эстони, Япон (Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайд огцруулна.)
Ерөнхийлөгч	13	БНСУ, Доминикан, Индонез, Исланд, Киргиз, Литва, Сингапур, Словак, Турк, ХБНГУ, Финланд, Франц, Чили
Хаан	4	Бельги, Дани, Испани, Нидерланд

Хүснэгт 9. Улс орнуудад засгийн газрын тэргүүн болон гишүүдийг огцруулах субъект

Судалгаанд хамрагдсан 30 орны Үндсэн хуулиар Ерөнхий сайд болон Засгийн газрыг огцруулж буй зохицуулалтыг авч үзвэл Ерөнхий сайд огцровол Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр огцрох зохицуулалттай 9 улс (Бельги, Герман, Испани, Киргиз, Латви, Словак, Эстони, Япон) байна.

2.2. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хууль тогтоох эрх мэдэл, засгийн газар болоод шүүхийн бие даасан байдлыг хангах, нутаг нэгж дэвсгэрийн тухай хуулийг илүү боловсронгуй болгох зэрэг хэд хэдэн санааг өөрчлөн сайжруулсан. Гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд оруулах гол өөрчлөлтүүд нь Засгийн газрын бие даасан, танхимын зарчмыг бэхжүүлэх, гүйцэтгэх эрх мэдлийн томилгоонд оролцох Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын бүрэн эрхийг хумьж, засгийн газрын бүрэн эрхийг тодорхой болгоход чиглэсэн.²⁶

- **Ерөнхий сайд танхимаа бүрдүүлэх тухай**

39.4 Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Хүснэгт 10. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт

1992 оны Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт “Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно”, Хорин тавдугаар зүйлийн 25.1.6 дахь заалтад “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг..... томилох, чөлөөлөх, огцруулах” нь Улсын Их Хурлын бүрэн эрх байсан. Ерөнхий сайд танхимын гишүүддээ хариуцлага тооцох эрх мэдэлгүй, засгийн газрын гишүүд Улсын Их Хурал, Ерөнхий сайд хоёрын хэнийх нь өмнө хариуцлага хүлээх нь тодорхойгүй тул засгийн газрын танхимаар ажиллах зарчимд саад учирч байсан. Иймээс 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлж, огцруулах тухай Үндсэн хуулийн 25.1.6-д байсан Улсын Их Хурлын бүрэн эрхийг хасаж, 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын тухай

²⁶ Хууль дээдлэх ёс, цуврал 84, 2021

хуульд нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам гэсэн 4 дүгээр зүйлийг өөрчлөн найруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь дараах ач холбогдолтой.

1. Ерөнхий сайд танхимаа өөрөө бүрдүүлдэг болсон нь Улсын Их Хурлаас гүйцэтгэх засаглалд хяналт тавих, хариуцлага нэхэх эрхийг нэмэгдүүлнэ.
2. Улсын Их Хурлын олонх дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд тухайн салбарын бодлогыг хамгийн сайнаар хэрэгжүүлэх хүнийг томилох шаардлага тулгарах бөгөөд хэрэв тэгж чадаагүй тохиолдолд танхимаараа огцрох эрсдэл үүснэ.
3. Улсын Их Хурлын гишүүд яам, төрийн албанд томилгоо хийх асуудал багассанаар тогтвортой байдлыг нэмэгдүүлж, 4 жилийн хугацаанд хийсэн ажилд үнэлэлт, дүгнэлт өгөх боломжтой.

• **Засгийн газарт итгэл үзүүлэх тухай**

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль	2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр
<p>44. Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэж Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.</p>	<p>44.1. Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар шийдвэрлэнэ.</p>
	<p>44.2. Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.</p>

Хүснэгт 11. Үндсэн хуулийн 44.1 болон 44.2. дахь хэсгийн нэмэлт, өөрчлөлт болон өмнөх зохицуулалтын харьцуулалт

Парламент, Засгийн газар хоорондын хяналт тэнцэл, харилцан хамааралтай байдлыг зохицуулдаг нэг чухал асуудал нь Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тухай байдаг. 1992 оны Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд “Итгэл үзүүлэх тухай” хуульчлагдсан ч яг ямар асуудлаар итгэл үзүүлэх, мөн итгэл үзүүлээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авах тухай асуудлыг хөндөөгүй тул өнөөг хүртэл практикт хэрэгжээгүй ирсэн. Үүний улмаас УИХ-ын олонхтой бодлогын зөрүү үүсвэл хагалах бүтээлч боломж дутмаг байв.²⁷ Үүнийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тодотгож Ерөнхий сайд улсын төсөв, бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцохоор, тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг 30 хоногийн

²⁷ О.Мөнхсайхан, Гурван парламент дамжсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталлаа, 2019, <https://ikon.mn/n/1q5f>

дотор томилохоор, хэрэв уг хугацааны дотор томилж чадаагүй бол Улсын Их Хурлыг тарааж ээлжит сонгууль зарлахаар тусгасан.

Органик хуулиудыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх ажлын хүрээнд 2020 оны 05 дугаар сард Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг баталж, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан.²⁸

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “Ерөнхий сайд Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, төсөв тэдгээрийн зүйл, хэсэг, заалтын талаарх өөрийн байр суурь болон Улсын Их Хурлаас дэмжлэг хүсэж байгаа асуудлыг тодорхой илэрхийлсэн байна. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайд огцорно”,

26.3 дахь хэсгийг “Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолыг баталсан бол энэ хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлыг дэмжсэнд тооцно. Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх асуудлыг 6 сарын дотор дахин санаачлахгүй”,

26.4 “Улсын Их Хурал өөрт нь итгэл хүлээлгэж байгааг нотолсон болон огцрох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол энэ тухай шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Засгийн газар уг асуудлыг өөрөө санаачлан авч хэлэлцэхгүй” гэж нарийвчилсан журмыг тогтоосон байна. 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн зохицуулалтаас харвал өөрт нь итгэл хүлээлгэж байгааг нотолсон болон огцрох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол Засгийн газар 6 сарын дотор дахин уг асуудлыг өөрийн санаачилгаар хэлэлцэхгүй, харин Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс Засгийн газрыг огцруулах санаачилга гаргах тохиолдолд хугацааны хязгаарлалт тавьж өгөөгүй байна.²⁹ 26.3 болон 26.4 дэх заалтаар Засгийн газар болон Ерөнхий сайдад хугацааны хязгаарлалт тогтоосон мөртлөө Улсын Их Хурал өөртөө хязгаарлалт тогтоогоогүй байгаа нь Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрыг огцруулах асуудлыг хэзээ ч тавьж болдог томилгооны өргөн бүрэн эрхээ хадгалсан зохицуулалт болжээ.³⁰

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг тодруулан хуульчилснаар:

1. Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдаж буй чухал асуудлыг парламентад тавьж шийдвэрлүүлнэ.
 2. Эрх мэдлийн хянал тэнцэл, уялдаа холбоог сайжруулах
 3. Улсын Их Хурал, Засгийн газар бодлогын хувьд нэгдмэл байх боломжийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой.
- **Засгийн газрыг огцруулах тухай**

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль	2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр
43.1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа	43.1. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав

²⁸ Хууль дээдлэх ёс, цуврал 84, 2021, 181 дэх тал

²⁹ Мөн тэнд

³⁰ Мөн тэнд

<p>Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.</p> <p>43.2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.</p> <p>43.3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>43.4. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>	<p>хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.</p> <p>43.2. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.</p>
---	--

Хүснэгт 12. Үндсэн хуулийн 43.1 болон 43.2 дахь хэсгийн нэмэлт, өөрчлөлт болон өмнөх зохицуулалтын харьцуулалт

Засгийн газрын бүрэн эрхийн дундаж хугацаа 1.8 жил байгаа нь нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх бодлого тогтвортой хэрэгжиж үр дүнг үзэх боломж байдаггүй. Тиймээс 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрыг огцруулах дөрвөн янзын боломж байсныг нэг болгон өөрчилсөн. Ингэхдээ Улсын Их Хурлын гишүүдийн олонх цөөнхийн харьцаа ойролцоо байгаа тохиолдолд цөөнхөөс ерөнхий сайд тодрох магадлалтай, хэзээ ч Ерөнхий сайд огцрохгүй байх нөхцөл үүсэх, огцруулах дээр санал нэгдсэн ч дараагийн Ерөнхий сайд дээр тохиролцоонд хүрч чадахгүй байх зэрэг эрсдэл байгаа гэж үзэн конструктив зарчмаар бус гишүүдийн олонхоос Ерөнхий сайдыг огцруулах саналыг тавьсан тохиолдолд түүнийг хэлэлцэн батлах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэн одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дөчин гурав дугаар зүйлийн 43.1 болон 43.2 дахь заалтуудыг найруулан өөрчилжээ.³¹ Конструктив механизмыг Үндсэн хуульд тусгах асуудал олон удаа хэлэлцэгдэж байсан ч дэмжлэг аваагүй тул, Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг ердийн олонхоор шийдвэрлэж байсныг туйлын олонхоор болгон өөрчилсөн.³² Мөн Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно гэх заалт нь танхимын зарчмыг илэрхийлж, хамтын хариуцлагыг тодруулсан байна. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрыг огцруулах асуудлыг өөрчлөн шинэчилснээр:

1. Засгийн газрын тогтвортой үйл ажиллагааг нэмэгдүүлэн, бодлогыг тууштай хэрэгжүүлэх боломжийг дээшлүүлэх

³¹ Хууль дээдлэх ёс, цуврал 84, 2021, 180 дах тал

³² Мөн тэнд

2. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох тул сайд нар нэгдмэл зорилготой, хариуцлагатай ажиллах нөхцөл бүрдэх
3. Сайдын хариуцлагагүй байдал танхимаар нь огцрох эрсдэл дагуулах тул засгийн газрын гишүүдийн сахилга, хариуцлага сайжрах зэрэг ач холбогдолтой.

• **Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний ажлыг хавсран гүйцэтгэх тухай**

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль	2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр
39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.	39.1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.

Хүснэгт 13. Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн нэмэлт, өөрчлөлт болон өмнөх зохицуулалтын харьцуулалт

Монгол Улсад 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш 1999 онд Үндсэн хуульдаа нэг л удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ үед Үндсэн хуулийн 29-р зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэснийг “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэж өөрчлөн найруулсан. Үүнийг Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон боловч 2000 оны 12 сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан. Энэ өөрчлөлтийн талаар “Засгийн газрын гишүүнээс бусад” гэдэг өөрчлөлт оруулсан нь Засгийн газрын үйл ажиллагаанд парламентын тавих хяналтыг сулруулсан гэх үндэс бий болсон.³³ Үүнээс хойших Засгийн газруудад Улсын Их Хурлын гишүүн давхар албан тушаал хаших нь ихэссээр 2017 оны У.Хүрэлсүхийн засгийн газар 100 хувь Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн. Энэ нь хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх засаглалын хяналт тэнцлийг алдагдуулж, засгийн газрын бие даасан байдлыг үгүйсгэсэн хэрэг гэж үзэн, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарсан.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлах, хуулийн төсөл боловсруулах зорилгоор байгуулагдсан 2014, 2016 оны ажлын хэсгүүдийн санал, 2017 оны бүх нийтийн зөвлөлдөх зөвлөлөөс гарсан саналд засгийн газрын гишүүнийг бүхэлд нь УИХ-ын гишүүн байхыг дэмжихгүй байгаа хэдий ч ерөнхий сайд болон үндсэн чиг үүргийн яамдын сайд нарыг нэгэн зэрэг УИХ-ын гишүүн байж болохыг дэмжсэн байна. Чингэхдээ улс төрийн тогтвортой байдлыг хангах үүднээс засгийн газрын гишүүдийн тодорхой хувь нь УИХ-ын гишүүн байх нь давуу тал бий болгоно гэдэгт үндэслэжээ.³⁴ Мөн үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан “Давхар дээлийг бүрэн хориглохоос яагаад татгалзсан бэ гэхээр парламент дахь олонх ард түмний итгэл авч гарч ирээд мөрийн хөтөлбөртөө тулгуурлан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг

³³ Конрад-Аднауэр-Сан, Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа, 2018 он, 66 дахь тал

³⁴ Г.Дугаржав, Ерөнхий сайдыг томилох, Засгийн газар бүрдүүлэх үйл явцад Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн хэрэгжүүлж байгаа эрх, үүрэгт хийсэн шинжилгээ, 2018, 89 дэх тал

баталж, Засгийн газар нь тэрний дагуу бодлогоо боловсруулж, УИХ руу оруулж ирээд, тэр нь зөв зүйтэй бол хэлэлцэн батлаад, хамтарч ажиллаж байж үр дүн гарна. Ингэж уялдаа холбоотой ажиллахад засгийн газрын зарим гишүүн УИХ-ын гишүүн байх нь чухал үүрэгтэй”³⁵ гэж үзжээ. Гучин есдүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “ засгийн газар ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэж заасан нь:

- Улсын Их Хурал ба Засгийн газрын харилцан хяналт тэнцэл сайжирч, чиг үүргийн давхцал арилна.
- Засаглал хуваах онолыг хэрэгжүүлэх, гүйцэтгэх засаглалыг хууль тогтоох байгууллагаас хараат бус байх боломжийг нэмэгдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой.

2.3. 2020 оны сонгуулийн дараах Монгол Улсын Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн

2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Монгол Ардын Намаас 62, Ардчилсан намаас 11, Та бидний эвслээс /МАХН-ИЗНН-МҮАН/ 1, “Зөв Хүн Электорат” эвслээс 1 , бие даан нэр дэвшигч 1 хүн тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон. 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар Монгол Улсын 32 дахь Ерөнхий сайдаар Л.Оюун-Эрдэнийг томилсон. Тэрээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн Гучин есдүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайд танхимын гишүүдээ өөрөө бүрдүүлсэн.

Албан тушаал	УИХГ мөн эсэх	Нэрс
Шадар сайд	Тийм	С.Амарсайхан
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	Үгүй	Ц.Нямдорж

Хүснэгт 14. Шадар сайд болон засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга

ДД	Яам	УИХГ мөн эсэх	Нэрс
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Үгүй	Б.Бат-Эрдэнэ
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Тийм	Х.Нямбаатар
3	Гадаад харилцааны сайд	Үгүй	Б.Батцэцэг
4	Соёлын сайд Ч.Номин	Үгүй	Ч.Номин
5	Эрүүл мэндийн сайд	Үгүй	С.Энхболд
6	Боловсрол, шинжлэх ухааны сайд	Тийм	Л.Энх-Амгалан
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Үгүй	А.Ариунзаяа
8	Барилга хот байгуулалтын сайд	Үгүй	Б.Мөнхбаатар
9	Батлан хамгаалах яам	Үгүй	Г.Сайханбаяр
10	Зам тээврийн хөгжлийн сайд	Үгүй	Л.Халтар

³⁵ О.Мөнхсайхан, Гурван парламент дамжсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталлаа, 2019, <https://ikon.mn/n/1q5f>

11	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	Үгүй	Г.Ёндон
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Үгүй	З.Мэндсайхан
13	Эрчим хүчний сайд	Үгүй	Н.Тавинбэх
14	Сангийн сайд	Тийм	Б.Жавхлан
15	Эдийн засаг, хөгжлийн яам	-	Түр хариуцах Б.Жавхлан
16	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	-	Түр хариуцах Л.Энх-Амгалан

Хүснэгт 15. Монгол улсын засгийн газрын бүрэлдэхүүн

Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар 2021 оны 2 дугаар сараас 14 яамтайгаар ажиллаж эхэлсэн бөгөөд сайд нараас 7 нь өмнөх засгийн газарт ажиллаж байсан. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн Гучин Есдүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “...Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэж заасны дагуу шадар сайд, хууль зүй дотоод хэргийн сайд, боловсрол шинжлэх ухааны сайд, сангийн сайдын албан тушаалыг тус тус Улсын Их Хурлын гишүүд хавсран гүйцэтгэж байна. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн өөрчлөлтөөр Эдийн засаг, хөгжлийн яам болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулсан. Ингэснээр Засгийн газар нь 16 яамны бүтэц, бүрэлдэхүүнтэй болсон бөгөөд 2022 оны 01 сарын 06-ны өдрөөс Эдийн засаг, Хөгжлийн яамны түр хариуцсан сайдаар Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны түр хариуцсан сайдаар БШУ-ны сайд Л.Энх-Амгалан тус тус томилогдсон.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.1 “Эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ”³⁶ гэж хуульчилсан байдаг. Үүний дагуу 2022 оны 01 сарын 17-ны Засгийн Газрын ээлжит бус хуралдаанаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанг ажлын хариуцлага алдсан хэмээн үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүний оронд Б.Бат-эрдэнийг Улсын Их Хурлын чуулганд танилцуулж, сайдаар томилсон байдаг. Танхимын зарчим ёсоор Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцрох тул, засгийн газрын гишүүн алдаа гаргасан тохиолдолд Ерөнхий сайд хариуцлага тооцох нь засгийн газрын тогтвортой байдлыг хангах, хамгаалахад чухал нөлөөтэй.

³⁶ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он

ДУГНЭЛТ

1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш засаглалын тогтворгүй, үр нөлөөгүй байдал үргэлжилсээр ирсэн бөгөөд бодлого, шийдвэрийн тогтвортой байдлыг бий болгох хэрэгцээ шаардлага тулгарсаар байсан. Энэ нь 2019 оны Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шалтгаан болсон билээ. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхий сайдад нэр дэвшигчийн нэрийг Улсын Их хурал руу оруулах нь Ерөнхийлөгчийн заавал гүйцэтгэх үүрэг болж, Ерөнхий сайд танхимын гишүүдээ томилж, чөлөөлж, огцруулах эрх мэдэлтэй, Засгийн газрыг ердийн олонхоор огцруулдаг байсныг дийлэнх олонхоор шийдвэрлэхээр болж, Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх асуудлыг тодорхой болгосон зэрэг өөрчлөлтүүдийг тусгажээ. 2020 оны сонгуулийн дараа байгуулагдсан Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу танхимаа өөрөө бүрдүүлсэн бөгөөд тэдгээрээс шадар сайд, хууль зүй, дотоод хэргийн сайд, боловсрол, шинжлэх ухааны сайд, сангийн сайд гэсэн дөрвөн засгийн газрын гишүүний албыг улсын их хурлын гишүүд давхар хашиж байна. Мөн Засгийн газрыг огцруулах дөрвөн боломжийг нэг болгож өөрчилсөн нь засгийн газрын дундаж хугацаа 1,8 жилээр хэмжигддэг засаглалын хямрал нүүрлэсэн манай улсын хувьд Засгийн газрын тогтвортой байдлыг хангах бололцоог бүрдүүлсэн юм. Засгийн газар тогтвортой байснаар төрийн бодлого тууштай хэрэгжиж, үр дүнг үзэж үнэлэлт, дүгнэлт хийх боломжийг олгодог. Үндсэн хуулиар гүйцэтгэх эрх мэдэлтэй холбоотой олон өөрчлөлтүүдийг хийсэн нь үүнтэй холбоотой. Л.Оюун-Эрдэнийн Засгийн газрын бүрэлдэхүүн өмнөх засгийн газрын бодлогын залгамж чанарыг үргэлжлүүлэн, өөрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрэлдсэн гэж хэлж болох бөгөөд үр дүн, үнэлгээг дараагийн сонгуулиар харах үлджээ.

3. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 2019 ОНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ

ОРШИЛ

Азийн сан болон Монгол Улсын Их Сургууль /Хууль зүйн сургууль, ШУС-Улс төр судлалын тэнхим/ хамтран гүйцэтгэж буй Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой судалгааны сүүлийн тайлан буюу гуравдугаар судалгаанд бид Монгол улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотой дотоодын болон гадаадын эрдэмтэн судлаачдын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, түүнтэй холбогдуулан хийсэн бие даасан болон хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний нийтлэл, өгүүллийн агуулга, ач холбогдлыг судаллаа.

Судалгаанд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан дотоодын их, дээд сургуулиуд, судалгааны институт, төрийн бус байгууллагуудын болон Монголд үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын улс төрийн сангуудаас эрхлэн гаргадаг бодлогын судалгаа, сэтгүүл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлүүдийг судлав. Мөн олон улсын нэр хүнд бүхий судалгааны институт дээрх Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдох нийтлэл, өгүүллийг судалж энэ удаагийн тайлангаар танилцуулж байна.

3.1. Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн талаарх дотоодын эрдэмтдийн байр суурь

Дотоод болон гадаадын эрдэмтдийн 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл хэвлүүлсэн жагсаалт:

Дотоодын сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэл:

Хүснэгт 16: Дотоодын сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлийн жагсаалт

УЛС ТӨРИЙН АГУУЛГА БҮХИЙ			
№	Судлаач	Судалгааны нэр	Судалгааны агуулга:
1	Д.Бумдарь, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, дэд профессор	“Бодлогын намыг төлөвшүүлэх нь” ³⁷	Монгол Улсын Үндсэн Хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөд улс төрийн намын төлөвшил, намын системийн хөгжлийг чиглүүлэхэд чухал нөлөө үзүүлэх хэд хэдэн заалт багтсан. “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана”

³⁷ Д.Бумдарь, Я.Төгөлдөр “Бодлогын намыг төлөвшүүлэх нь”, Нээлттэй Нийгэм Форум, УБ хот, 2022 он https://www.forum.mn/res_mat/2021/Chukhal%20sedev_Political%20Party-1.pdf

[Сүүлд үзсэн: 2022 оны 3 сарын 13]

	<p>Я.Төгөлдөр, ШУТИС, Улс төр судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор</p>		<p>гэсэн заалтыг судлаачид сонгон авч энэхүү судалгааны ажлаар Улс төрийн намын тухай хуульд уг заалтыг тусгахад ямар асуудлыг голлон анхаарах нь чухал болохыг дотоодын болон олон улсын судалгааны байгууллага, их дээд сургуулийн багш, судлаачдын гаргасан дүн шинжилгээ, зөвлөмжид үндэслэн хураангуйлан бичжээ. Үүнд “Бодлогын нам” гэдгийг тодорхойлоод, бодлогын намын шинж, шалгуур үзүүлэлтүүд болон бодлогын намын тухай сайн туршлагыг Бразил, Энэтхэг, Турк, Пост социалист орнуудаас Украин улсыг сонгон авч харьцуулан судалжээ.</p>
<p>2</p>	<p>Д.Бумдарь, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш, дэд профессор Я.Төгөлдөр, ШУТИС, Улс төр судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор</p>	<p>“Эвлэлдэн нэгдэх эрх ба улс төрийн намын хатуу гишүүнчлэл”³⁸</p>	<p>Энэхүү судалгаагаар Монгол Улсын Үндсэн Хуульд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөд улс төрийн намын төлөвшил, намын системийн хөгжлийг чиглүүлэхэд чухал нөлөө үзүүлэх хэд хэдэн онцлох заалтын нэг болох арван есдүгээр зүйлийн хоёрт “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” гэснийг сонгож Улс төрийн намын тухай хуульд уг заалтыг тусгахад ямар асуудлыг голлон анхаарах нь чухал болохыг дотоодын болон олон улсын судалгааны байгууллага, их дээд сургуулийн багш, судлаачдын гаргасан дүн шинжилгээ, зөвлөмжид үндэслэн хураангуйлан судалжээ. Судалгааны агуулга нь манай улсад үйл ажиллагаа явуулж буй Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 35 нам болон намуудын олонх нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж чаддаггүй, нийгэмд танигдаагүй, олон намын систем төлөвшиж чадаагүй зэрэг асуудлыг хөндөж өнөөгийн намын системд тулгамдаж буй асуудлыг шийдэх Улс төрийн намын тухай</p>

³⁸ Д.Бумдарь, Я.Төгөлдөр, “Эвлэлдэн нэгдэх эрх ба улс төрийн намын хатуу гишүүнчлэл” бодлогын хэлэлцүүлэг, Нээлтэй Нийгэм Форум, УБ хот, 2022 он https://www.forum.mn/res_mat/2021/Chukhal%20sedev_Political%20Party-2.pdf, [Сүүлд үзсэн: 2022 оны 3 сарын 09]

			хуульд шинэчилсэн найруулга зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн хийгээд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тус заалтыг ойлгох, гадаадын улс орнуудын сайн туршлагын судалж танилцуулсан байна.
3	“Нээлттэй Нийгэм Форум”, Я.Төгөлдөр, Улс төр судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор, ШУТИС-ийн БУХС-ийн Нийгмийн ухааны салбарын эрхлэгч	“Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” Санал, Зөвлөмж ³⁹	Энэхүү санал зөвлөмжөөр Монголын улс төрийн намын төлөвшилд тулгамдсан асуудлыг тодорхойлж, намын эрх зүйн орчны шинэчлэлийн талаарх иргэд олон нийтийн хүлээлт, оролцогч талуудын байр суурь, хандлагыг тоон болон чанарын судалгаагаар тандан судалж, бодлогын алтернатив зөвлөмж боловсруулахыг зорьжээ. Судалгааны ажлаар 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр намд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэж тусгасан тул зөвхөн төрийн санхүүжилтийн хүрээнд асуудлыг дэлгэрүүлэн судалсан байна. Судалгааны ажлын гадаадын улс орнуудын харьцуулсан судалгаа хэсэгт “үндэсний хэмжээний сонгуульд өрсөлдөж буй нам/нэр дэвшигчдэд төрөөс санхүүжилт олгодог эсэх” байдлыг тодорхойлж, Төв ба зүүн Европын орнуудын улс төрийн намын санхүүжилтийн зохицуулалтыг мөн дурдсан байна. Судалгааны дүгнэлт хэсэгт дэлхийн улс орнуудын улс төрийн намын тодорхойлолт, санхүүжилт, дотоод ардчилал, эрх зүйн орчны өнөөгийн байдал түүний шинэчлэл, чиг хандлагыг харьцуулан судалж, үндсэн таван зорилтын хүрээнд санал, зөвлөмж хүргүүлсэн байна.
4	Э.Гэрэлт-Од МУБИС, НХУС-ийн Нийгмийн ухааны	“Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр	Энэхүү судалгааны ажлаар 1990 оноос хойш ардчилсан, олон намын тогтолцооны түүх, 1990 оны болон 2005 оны улс төрийн намын

³⁹ “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал”, бодлогын хэлэлцүүлэг, Нээлттэй Нийгэм Форум, ШУТИС, УБ хот, 2021 он

https://www.forum.mn/res_mat/2021/PoliticalPartiesLaw.pdf

[Сүүлд үзсэн: 2022 оны 3 сарын 09]

	<p>тэнхимийн ахлах багш, доктор /Ph.D/</p>	<p>суурь”, Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл⁴⁰ “Монгол дах намын эрх зүй ба намуудын байр суурь”</p>	<p>тухай хууль, түүний өөрчлөлт, өнөөдрийн нийгэм, улс төрийн хэрэгцээ, намын тухай хуулийг өөрчлөх санаачилгууд, улс төрийн зарим шийдэл ба Үндсэн хуулийн шинэчлэлийн дагуу болон сул тал, намуудын байр суурийг хөнджээ.</p> <p>Судлаач Монгол Улсын улс төрийн намын эрх зүйн хүрээнд хийх шинжилгээ нь Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуулиудад тулгуурлах болохыг дурдаад намын үүсэл хөгжил, намын бүтэц зохион байгуулалт, барууны анхны нам болон манай улсын анхны улс төрийн намуудын үүсэн байгуулагдах үеийн гишүүдийн тоо, 1990, 2005 оны Улс төрийн намын шинэчилсэн найруулга, түүний ач холбогдлыг дурджээ. Мөн “1992, 2005, 2011, 2015 онуудад УИХ-ын сонгуулийн хуулийг шинэчлэн баталж байсан ч, эрх баригч намууд сонгуулийн тогтолцоог сонгууль бүрийн өмнө өөрчилж ирсэн явдал нь намын төлөвшилд эергээр нөлөөлж чадаагүй” гэж судлаач үзсэн. “Цаашлаад намын эрх зүйн орчин сул, шударга бус байгаа нь дараах үр дагавартай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ноёрхогч нэг нам, бусад намуудтай намын тогтолцоо бүрдсэн. - УИХ-д суудалтай намууд давуу эрх олгодог төрийн дэмжлэг тогтсон. - Эрх баригч намууд төрийн нөөц, хөрөнгийг ашиглах сонирхолтой болсон. - Сонгуулийн саналын хуудасны эхэнд МАН, АН-ууд ямагт бичигдэх болсон. - МАН, АН-ууд улс төрийн зах зээлийг сүлжээний аргаар барьдаг. - Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг бэхжүүлэх, эвлэлдэн нэгдэх улс төрийн байгууллага болох мөн чанараа алдсан.
--	--	---	---

⁴⁰ Э.Гэрэлт-Од, “Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь”, *Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл* 2020, 32-43 дахь тал.

			<ul style="list-style-type: none"> - Намууд Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрддөггүй. - Намуудын санхүү ил тод биш. - Намууд нэр хүнд, дэмжлэгээ алдсаар байна” гэж үзжээ. <p>Судалгааны ажлын төгсгөлд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 19^{1.1}, 19^{1.3} дах заалтууд нь “улс төрийн намыг үүрэгжүүлэх сайн заалт бөгөөд улс төрийн намын тухай хуулийг яаралтай өөрчлөх, дотоод ардчилалтай болох, санхүүжилтийг ил тод болгох, намууд хуулийг дагаж мөрдөх хөшүүрэг болох сайн талтай” гэж үзжээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх, батлах үйл явцыг дүгнэхэд намтай холбоотой 19^{1.2} дахь заалтын талаар дараах дүгнэлтийг судлаач хүргүүлжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 1990 оноос өмнө намын ерөнхий зүйл нь монопол зохицуулалттай байжээ. - 1990 оноос хойш гучин зүйлд намын эрх зүйн картель⁴¹ зохицуулалт бүрджээ. - МАН, АН-ууд өөртөө ашигтай, давуу байдлаа хадгалж үлдэх улс төрийн сонирхол байна. - Гуравдагч хүчний намуудын дарга нарт жижиг намууд байх нь МАН, АН-уудад давуу байдал үүсгэж байна. - УИХ шинээр батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулан Улс төрийн намын тухай хуулийг батлах үүрэг хүлээж байгаа ч улс төрийн хүсэл зориг харагдахгүй байна. - Хамгийн ноцтой нь Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг дордуулсан бөгөөд ирээдүйд
--	--	--	--

⁴¹ Картель (фр. cartel) нь монополь холбоо эсвэл бие даасан үйлдвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувиа хадгалж, санал болгож буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийг тодорхойлох гэрээний нэг хэлбэр.

			иргэд шинээр нам байгуулах улс төрийн эрхээ эдлэхэд хүндрэл учирч байна.
5	Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (АСДҮОУХ), 2020 он	“Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт” Улс төрийн санхүүжилтийн гарын авлага ⁴²	2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан бичсэн энэхүү Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийн талаарх уг гарын авлагыг Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (АСДҮОУХ) эрхлэн гаргасан бөгөөд санхүүжилттэй холбоотой дэлхийн бараг бүх улс орны мэдээллийг нэг дор багцлан танилцуулсан цогц бүтээл болжээ. Судалгаа агуулга нь Улс төрийн санхүүжилтийн тухай танилцуулга, тогтолцоо, эрх зүйн орчин, улс төрийн бодит нөхцөл, Африк, Ази, Латин Америк, Зүүн, Төв, Зүүн-Өмнөд Европ болон Төв Ази, Умард, Баруун ба Өмнөд Европтой харьцуулан судалж сайн туршлага жишээг иш татсан. Цаашлаад Улс төр дэх эмэгтэйчүүд: Жендерийн тэгш байдлын төлөөх санхүүжилт болон улс төрийн санхүүжилтийн суурь асуудлыг тодорхойлон гаргасан, дүгнэлт зөвлөмж бүхий 10 бүлэг судалгаа байна.
6	Г.Чулуунбаатар Ш.Батсүх Б.Ганцоож	“МОНГОЛЫН АРДЧИЛАЛ: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж” Хоёрдугаар бүлэг “Төлөөллийн ардчиллын үндсэн сорилтууд” ⁴³	Энэхүү судалгааны хоёрдугаар бүлэг нь Төлөөллийн ардчиллын хөгжил, төлөвшлийн явцад үүсэж буй бодлого, эрх зүйн орчны сорилтуудыг судлахдаа бодлогын орчинд хамаарах сорилт, бэрхшээл болон эрх зүйн орчинд хамаарах сорилт бэрхшээл гэсэн хоёр ангилалд судалгааны ажлын хоёрдугаар бүлэг “Төлөөллийн ардчиллын үндсэн сорилтууд” бүлэг бичигджээ. Эдгээрээс эрх зүйн орчинд

⁴² Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (АСДҮОУХ) “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт”, 2020 он УБ хот, https://www.forum.mn/res_mat/2020/PartyFinancing_LowResolution.pdf

[Сүүлд үзсэн: 2022 оны 03 сарын 10]

⁴³ “Конрад Аденауэр Сан”, Судлаач Г.Чулуунбаатар, Ш.Батсүх, Б.Ганцоож “МОНГОЛЫН АРДЧИЛАЛ: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж” Хоёрдугаар бүлэг “Төлөөллийн ардчиллын

			<p>хамаарах сорилт бэрхшээлд Монгол Улсын Үндсэн хууль бол Монголын ардчиллын улс төр, эрх зүйн суурь баталгаа мөн хэмээн тодорхойлоод 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан ардчиллын хөгжилд шууд холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг тоймлон судалсан байна. Үүнд Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан 6.2, 19.1, 28-р зүйл, 29.3, 49.5, 57.3, 59.2 зэргийн тус бүрийн агуулга, ач холбогдлыг тайлбарлажээ. Цаашлаад төлөөллийн ардчиллын амин сүнс нь сонгуулийн тогтолцооны асуудал хэмээн тодорхойлоод УИХ дахь олонх болсон нам сонгууль болохоос 6 сарын өмнө Сонгуулийн тухай хуулиа шинээр баталдаг жишиг тогтсоноос шат шатны сонгуульд шинээр нэр дэвших гэж байгаа улс төрчид, намуудад тодорхойгүй байдал үүсгэж, сонгуулийн өрсөлдөөний шударга байдал алдагдсаар ирсэн явдлыг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасан нь цаашдаа сонгуулийн хууль тогтоомжийг улс төрөөс, ялангуяа сонгуулийн өмнөх нөхцөл байдлаас хамааруулж өөрчлөх боломжийг хязгаарлаж өгсөн явдал гэжээ.</p>
7	<p>“Конрад Аденауэр Сан”, МУИС- ШУС- НУС Улс төр судлалын тэнхим, “Төрийн байгуулал судлал” сэтгүүл, Төрийн байгуулалтын</p>	<p>“Монгол дах ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” “Монгол дахь ардчиллын бэхжилт, сорилтын зарим</p>	<p>“Монгол дахь эрх мэдлийн төвлөрөл, засгийн газар, Парламент хоорондын харилцааны зарим асуудал” судалгааны бүлэгт Монгол дахь эрх мэдлийн төвлөрөл, Засгийн газар, парламент хоорондын харилцааны талаар өгүүлсэн. Ингэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасны дагуу УИХ-ын</p>

	<p>экспертийн зөвлөлийн зөвлөх: П.Амаржаргал Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд профессор, Төрийн байгуулалтын экспертийн зөвлөлийн судлаач: Д.Оргил Азийн сангийн Хотын засаглалыг сайжруулах төслийн дэд менежер</p>	<p>асуудлыг олон улсын харьцуулсан судалгааны үүднээс авч үзэх нь” бүлэг “2.4. Монгол дах эрх мэдлийн төвлөрөл, засгийн газар, Парламент хоорондын харилцааны зарим асуудал”бүлэг⁴⁴ 3.3. “Монгол улсад Ардчиллыг хэрэгжүүлэх эрх зүйн боломжийн судалгаа” бүлэг⁴⁵</p>	<p>сонгуульд ялсан нам ерөнхий сайдын нэрийг дэвшүүлж, Ерөнхийлөгч түүний нэрийг УИХ-д танилцуулдаг агуулга бүхий заалтыг судалж, Засгийн газар мөрийн хөтөлбөрөө саадгүй хэрэгжүүлэхэд санаачилга багатай байдал нь Улсын Их Хурал, Засгийн газар хоорондын харилцааны гажуудал гэдэгтэй судлаачид санал нэгддэг⁴⁶ тухай дурджээ. Тухайлбал зарим судлаач “Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.6-д УИХ нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар УИХ-д ажлаа тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах бүрэн эрхтэй гэх заалт нь УИХ-аас Ерөнхий сайдыг томилох, тэр бүү хэл Засгийн газрын гишүүн нэг бүрийг томилох эрх олгоод байгаа нь парламентын засагтай оронд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хооронд хянал-тэнцлийг хангахын тулд Ерөнхий сайдыг парламентаас сонгох явдлыг аль болох хөнгөвчилдөг, Засгийн газрын тэнхимийн гишүүдийг органик удирдлагын хувьд төрийн тэргүүнээс томилдог үндсэн механизмуудыг яг эсрэг хандлагыг илэрхийлж буй тул энэ зохицуулалтыг төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын эсрэг алхам хэмээн дүгнэжээ”⁴⁷. Энэхүү гажуудлыг шийдвэрлэхэд 2019 оны 11 дүгээр сарын 14- нд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт чухал хөшүүрэг болсон гэж судлаачид үзэж байна. Тухайлбал, “Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлт нь сүүлийн 20 жил яригдсан</p>
--	---	---	--

⁴⁴ “Конрад Аденауэр Сан”, МУИС- ШУС-НУС Улс төр судлалын тэнхим “Төрийн байгуулал судлал” сэтгүүл “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа”,240-242 дах тал, УБ хот, 2020 он, <https://bit.ly/3tYBljp> [Сүүлд үзсэн:2022 оны 3 сарын 10]

⁴⁵ Конрад-Аденауэр сан, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” /судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/ УБ хот, 2020 он 188-р тал <https://bit.ly/3tYBljp> [Сүүлд үзсэн:2022 оны 3 сарын 10]

⁴⁶ О.Машбат. (2015). Үндсэн хууль: Улстөр-эрхзүй, хянал-тэнцэл. Улаанбаатар: Эрх зүйт ёс сан. 167 дахь тал, дам ишлэв [2022 оны 03 сарын 09]

⁴⁷ О.Машбат. (2015). Үндсэн хууль: Улс төр-эрх зүй, хянал-тэнцэл. Улаанбаатар: Эрх зүйт ёс сан. 167 дахь тал.

			<p>асуудлыг иргэдийн санаа бодлыг сонсож, судлаачдын санал, шүүмжийг тусгаж, “...улс төрийн намууд болон Ерөнхийлөгчтэй зөвшилцөн шийдвэрлэж байгаа...” энэхүү нэмэлт, өөрчлөлт Засгийн газрыг тогтвортой, үр нөлөөтэй болгох, УИХ-ын үйл ажиллагааг сайжруулах, шүүхийг хараат бус, шударга болгох зэрэг асуудал энэ парламентын үед ийнхүү шийдэгдэж байна”. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зохицуулалтын хүрээнд дээр дурдсан парламент Засгийн газар хоорондын эрх мэдлийн харилцааны гажуудлыг залруулж чадах эсэхийг анхааралтай ажиглах шаардлага тулгарч хэмээжээ.</p> <p>Судалгааны ажлын 3.3-р бүлэгт “Монгол улсад Ардчиллыг хэрэгжүүлэх эрх зүйн боломжийн судалгаа”-г гүйцэтгэжээ. Энэ хэсэгт 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн 25.1.16 дэх хэсэгт холбогдох санал асуулгад оролцох иргэдийн ирц, олонхын санал авсан дүнгээр тухайн асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр тусгасныг ардчилсан нийгэмд төрийн эрх мэдлийг гагцхүү ард түмэн хэрэгжүүлдгийг эрх зүйн хувьд баталгаажуулсан суурь зохицуулалт гэж үзжээ. Цаашлаад Үндсэн хуулийн 19-ийн 2 дахь заалтад “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” гэсэн зохицуулалтыг нэмж оруулсан явдал нь “улс төрийн нам байгуулахад иргэд шууд оролцох эрх зүйн суурь зохицуулалт болсон, өөрөөр иргэдийн ийм өндөр босготой шууд оролцоотойгоор улс төрийн нам байгуулах болсон нь нэг талаар, улс төрийн намын төлөөлөх шинжийг нэмэгдүүлэх, нөгөө талаар, иргэн хүн үзэл бодол, итгэл үнэмшлийнхээ дагуу эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэх замаар нийгмийн улс төрийн харилцаанд оролцох боломжийг өргөтгөж байгаагаараа чухал ач холбогдолтой” гэж үзжээ.</p>
--	--	--	---

8	Э.Сундуй, Улс төр судлаач	<p>Засгийн газрыг байгуулахад эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцэл үйлчилж байгаа эсэхэд хийсэн шинжилгээ,</p> <p>Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Үндсэн хууль ба эрх зүйн ёс-ХП” (Шилдэг илтгэлийн эмхэтгэл), УБ., 2021</p>	<p>2019 оны 11-р сарын 14-нд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрыг байгуулахад хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хооронд эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцэл хангагдах нөхцөл хэрхэн нөлөөлсөн бэ? Тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь улс төрийн ямар үйл явц, нөлөөлөл үзүүлэхийг Монгол Улсын өнгөрсөн түүх, бусад улсын жишээгээр тайлбарлахад судалгааны зорилго чиглэжээ.</p>
9	Судлаач, Б.Улсболд	<p>Монгол Улсын Үндсэн хууль дахь намын дотоод ардчиллын зохицуулалттай холбогдох эрх зүйн шинэтгэл: харьцуулсан судалгаа⁴⁸</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуульд улс төрийн намууд дотоод зохион байгуулалтын хувьд ардчилсан зарчимд нийцсэн байх ёстой гэж заасан тул түүнтэй уялдсан эрх зүйн шинэтгэлийг хийхдээ олон талт нөхцөл байдлыг харгалзан үзэж, зохистой тэнцвэрийг олох нь нэн чухал асуудал болоод байгаа. Иймд тус эрдэм шинжилгээний илтгэлийн зорилго нь Үндсэн хуулийн улс төрийн намын тухай нэмэлттэй холбогдох эрх зүйн шинэтгэлийг хэрхэн хийж болох талаар харьцуулан судалж, сайн туршлагыг олж илрүүлэх, санал, зөвлөмж гаргахад үндэслэсэн болно.</p>
10	МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, Доктор Б.Эрдэнэдалай	<p>“Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтийн тулгамдсан асуудал, цаашдын хандлага” Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан</p>	<p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан батлагдан 2020 оны 01 сарын 09 ний өдрийн “Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” дугаар 02 тогтоолын хавсралтаар “Улс төрийн намын тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон түүнд холбогдох хууль тогтоомжид нэмэлт</p>

⁴⁸ Баттулгын Улсболд: Монгол Улсын Үндсэн Хууль дахь намын дотоод ардчиллын зохицуулалттай холбогдох эрх зүйн шинэтгэл: Харьцуулсан судалгаа (legaldata.mn)

		<p>асуудал, цаашдын хандлага судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж⁴⁹ “Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтийн тулгамдсан асуудал, цаашдын хандлага”</p>	<p>өөрчлөлт оруулах цаашлаад Улс төрийн санхүүжилтийн тухай бие даасан анхдагч хуультай болох тухай тусгагджээ. Энэхүү судалгааны ажлаар судлаач “Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай”⁵⁰ дугаар 02 тогтоолын хавсралтад тусгагдсан “Улс төрийн намын тухай” хуулийн шинэчилсэн найруулга болон анхдагч Улс төрийн санхүүжилтийн тухай хуулийн төсөлд холбогдох суурь судалгааг улс төрийн шинжлэх ухааны үүднээс Улс төрийн намын санхүүжилтийн онол, арга зүйн хандлагууд, намын санхүүжилтэд нөлөөлөх хүчин зүйлс, эх үүсвэр, олон улсын туршлага, Монгол дахь улс төрийн намын санхүүжилтийн тулгамдсан асуудал (1990 оноос хойш) болон Монгол дахь улс төрийн намын санхүүжилтийн өнөөгийн байдлын шинжилгээ, хяналт, хариуцлага гэсэн хэсгүүдэд нарийвчлан судалсан байна. Судалгааны ажлын дүгнэлтээр намын сонгуулийн ба сонгуулийн бус үеийн санхүүжилтийн тэгш боломжийг хангаж өгөх, жижиг болон шинэ намуудад санхүүжилтийн тусгай зохицуулалт, бодлого хэрэгтэй, санхүүжилтийн эх үүсвэрийн бүрдүүлэхэд олон жижиг санхүүжүүлэгч байх нь зүйтэй, хууль эрх зүйн зохицуулалтыг сайтар хийх шаардлагатай гэжээ. Судалгааны ажлын санал зөвлөмжөөр улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, тайлангаа шилэн дансаар дамжуулж мэдээлэх, сонгуулийн болон сонгуулийн бус компани ажлын хугацаанд</p>
--	--	--	--

⁴⁹ МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, Доктор Б.Эрдэнэдалай “Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтийн тулгамдсан асуудал, цаашдын хандлага” Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан асуудал, цаашдын хандлага судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, УБ хот, 2021 он, 9-50 дахь тал,

⁵⁰ “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” дугаар 02, хавсралт <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210458&showType=1> [Сүүлд үзсэн: 2022 оны 3 сарын 16]

			хандивын болон зардлын дүнгээ тухай бүрд олон нийтэд тайлагнахыг хуульчлах, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаанд хяналт тавих, шалгах, хариуцлага тооцох эрх бүхий албан ёсны бүтцийг бий болгох, хяналтын байгууллагад хяналт, аудит хийх боломж нөхцөлийг бүрдүүлж өгөх, улс төрийн намын санхүүжилтэд тавих хяналтыг цаг хугацааны хувьд тодорхой зохицуулах зэргийг санал болгожээ.
ЭРХ ЗҮЙН АГУУЛГА БҮХИЙ			
1	Хууль зүйн магистр Д.Баяр	Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-ийн нэмэлт өөрчлөлт ба хуулийн “Романтизм” ⁵¹	Тус өгүүлэл нь Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн зохицуулалтын үзэл сургаал, суурь зарчим, зорилгыг тодруулж, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр нэмэгдсэн “нийтийн” гэх томъёоллыг тайлбарлаж, уялдаа холбоог нь тодорхойлж, зургадугаар зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хэрхэн ойлгож, хуульчлах суурь зарчмыг хөнджээ.
2	МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал: газрын хэвлийн баялаг ашиглахад баримтлах зарчмууд ⁵²	Тус судалгааны ажлаар, 2019.11.14-ны нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6.2-д газрын хэвлийн баялгийг ашиглахтай холбоотой оруулсан шинэ заалтуудын үзэл баримтлалыг баталсан бүрэлдэхүүний хуралдааны тэмдэглэл болон бусад холбогдох эх сурвалжид тулгуурлан тодорхойлжээ. Байгалийн баялаг ашиглах бодлогыг тодорхойлоход Үндсэн хуулийн 6.2-т шинээр орсон заалтууд төдийгүй Үндсэн хуулийн бусад суурь зарчмыг цогцоор нь хамгийн сайнаар утгажуулан хэрэглэнэ гэсэн байр суурийг энэ өгүүллээр хамгаалжээ. Өгүүлэл нь байгалийн баялаг – төрийн нийтийн өмч, байгалийн баялаг ашиглахад баримтлах тусгай зарчмууд,

⁵¹ Д.Баяр: Монгол Улсын Үндсэн Хуулийн 6.2.-ийн Нэмэлт, Өөрчлөлт ба Хуулийн “Романтизм” (legaldata.mn)

⁵² О.Мөнхсайхан: Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал: газрын хэвлийн баялаг ашиглахад баримтлах зарчмууд (legaldata.mn)

			стратегийн ач холбогдол бүхий ашиг малтмалын орд ашигласны үр өгөөж, Үндсэн хуулийн бусад зарчмууд гэсэн дөрвөн бүлгээс бүрдсэн байна.
3	“Нээлттэй Нийгэм Форум” Д.Ганхүрэл, Д.Сүнжид, А.Түвшинтөгс, Б.Гүнбилэг, Н.Лхамсүрэн	“Үндсэн Хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийн үзэл баримтлалыг тодруулах нь” Бодлогын судалгаа, зөвлөмж ⁵³	Судлаачдын баг 2019 оны 11 дүгээр сард Үндсэн хуулийн Зургадугаар зүйлд нэмэлт, өөрчлөлтөөр орсон Зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийн үзэл баримтлалыг тодруулах замаар тус зохицуулалтыг хэрхэн ойлгож, салбар хуулиа түүнд нийцүүлэх талаар судлах бодит шаардлага тулгарч байна гэж үзсэний үндсэн дээр энэхүү судалгааг хийж гүйцэтгэжээ.
4	Нээлттэй нийгэм Форум 2022 оны 2 сар №28	“Үндсэн Хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийн үзэл баримтлалыг тодруулах нь” (шинэчилсэн хэвлэл) ⁵⁴	2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-аас баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанд баримтлах зарчим, үзэл санааг тодотгосон. Ингэхдээ Ерөнхийлөгч болон УИХ-аас зөвшилцлийн ажлын хэсэг байгуулан 6.2 дахь хэсгийг хэрхэн томъёолох талаар хэд хэдэн нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн байдаг. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “байгалийн баялаг ашигласны үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчим” мөн “төрийн нийтийн өмч” гэх зэрэг нэр томъёо 6.2 дахь хэсэгт буусан боловч агуулгын хувьд уг нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө ч дээрх үзэл баримтлал Үндсэн хуульд байсан гэдгийг энэхүү судалгаанд дурдагдсан эх сурвалжуудаас харж болно. Үндсэн хуульд зохицуулалтыг харьцангуй нарийвчилсан байдлаар оруулах нь эргээд цаг үеийн өөрчлөлтөөр түүнийг тайлбарлах хийгээд түүнд нийцсэн салбар хуулийн зохицуулалтыг батлах агуулгын хүрээг хумьдаг тал бий. Тиймээс шинээр тусгасан

⁵³ Д.Ганхүрэл, Д.Сүнжид, А.Түвшинтөгс, Б.Гүнбилэг, Н.Лхамсүрэн: Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийн үзэл баримтлалыг тодруулах нь (legaldata.mn)

⁵⁴ [Sud.Toim.28.Undsen.KhuuIin.6.2.pdf\(forum.mn\)](http://Sud.Toim.28.Undsen.KhuuIin.6.2.pdf(forum.mn))

			<p>нэр томьёог үгчилж бус үзэл баримтлал талаас нь тайлбарлах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орох нь түүнд салбар хуулиудыг нийцүүлж, тухайн салбар хууль нь бодит амьдрал дээрх харилцааг зохицуулж, эрх зүйн үр дагавар үүсгэх Үндсэн хуулийн зохицуулалтыг хэрхэн зүй зохистойгоор тайлбарлаж хэрэгжүүлэх вэ? гэдэг нь маш чухал юм. Тиймээс энэхүү судалгааны зорилго нь 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт тусгагдсан үзэл баримтлалыг хэрхэн ойлгох, түүнд салбар хуулиа хэрхэн нийцүүлэх чиглэлийг тодорхойлоход оршиж байгаа болно.</p>
5	Хуульч, судлаач С.Асланбек	<p>Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт орсон нэмэлт, өөрчлөлтийн зарим нэр томьёог хүний эрхийн үүднээс тайлбарлах нь⁵⁵</p>	<p>2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт оруулсан доорх нэмэлт өөрчлөлтийн “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэсэн хэсэгтэй холбогдуулан олон нийтийн сүлжээнд иргэдийн дунд буруу ташаа мэдээлэл, төөрөгдөл явж байгаа учир тус хэсгийг Хүний эрхийн үүднээс энэхүү судалгааны ажил тайлбарлахыг зорьжээ. Тодруулбал, Монгол улсын нэгдэн орсон Хүний эрхийн чиглэлийн 50 гаруй олон улсын гэрээ, баримт бичгийг хэрэглэх замаар нэр бүхий зарим нэр томьёог тайлбарлажээ.</p>
6	Хуульч, судлаач С.Асланбек	<p>Монгол Улсын Үндсэн хууль дахь үндэсний баялгийн сангийн тухай зохицуулалт ба олон</p>	<p>Монгол Улсад баялгийн сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоход олон улсын сайн туршлага, жишиг зохицуулалтыг өөрийн орны өнөөгийн байдал, тулгамдсан асуудалтай холбож, харьцуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажил чухал үүрэг гүйцэтгэх учир, тус судалгааны ажлаар</p>

⁵⁵ С.Асланбек: Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт орсон нэмэлт, өөрчлөлтийн зарим нэр томьёог хүний эрхийн үүднээс тайлбарлах нь (legaldata.mn)

		улсын туршлага ⁵⁶	Үндэсний баялгийн сангийн 1/онолын асуудал, ерөнхий ойлголтуудыг судалж, 2/олон улсын чиг хандлагад тулгуурлан, гадаад улсуудын баялгийн сангийн тогтолцоог харьцуулан судалж, жишиг болохуйц туршлагыг илрүүлэх замаар 3/дотоодын эрх зүйн зохицуулалт ба түүнд тулгамдсан асуудлыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэсэн 4/дүгнэлт, санал боловсруулжээ.
7	“Нээлттэй Нийгэм Форум” 2022 оны 2 сар №29 Г.Давааням (LL.D, Nagoya)	“Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт” ⁵⁷	Монгол Улсын 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн 6.2 дахь хэсгийн “төрийн өмч” гэсэн томъёоллыг “төрийн нийтийн өмч” гэж өөрчлөн найруулсан байна. Уг нэр томъёоны “цаад агуулга нь Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхол буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс газар, байгалийн баялгийн хувь заяаг шийдвэрлэнэ” ¹ гэсэн утгатай. Энэхүү Үндсэн хуулийн хэвшсэн нэр томъёог “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх болсон үйл явцын ард төрийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт өнөөг хүртэл хангалтгүй байснаас үүдэн төрийн өмчийг хувийн ашиг сонирхлын үүднээс захиран зарцуулах, үр ашиггүй болгох “нийтийн өмчийн эмгэнэл” (tragedy of the commons)-ийн асуудал өргөн хүрээнд үүссэнтэй холбоотой байж болно. Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагалдан ердийн хуулийн шинэчлэл хараахан хийгдээгүйн улмаас төрийн өмчийг харилцааг зохицуулж буй холбогдох хууль тогтоомж Үндсэн хуультай зөрчилдөх болсон. Тухайлбал, 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4.4-т “Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн (Монгол Улсын иргэн, гадаадын

⁵⁶ С.Асланбек: Монгол улсын үндсэн хууль дахь үндэсний баялгийн сангийн тухай зохицуулалт ба олон улсын туршлага (legaldata.mn)

⁵⁷ [Sud.Toim.29.Yapon.ulsiiin.turiin.umchiin.udirdlaga.pdf\(forum.mn\)](http://Sud.Toim.29.Yapon.ulsiiin.turiin.umchiin.udirdlaga.pdf(forum.mn))

			иргэн, харьяалалгүй хүн), бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно” гэх заалтыг дурдаж болох юм. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн шинэчлэхээс гадна “нийтийн өмчийн эмгэнэл”-ийг арилгах хүрээнд төрийн бүхий л төрлийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсэж байна. Энэ хүрээнд Япон Улсын туршлага, эрх зүйн зохицуулалтыг судалсан бөгөөд тус улс нь 1918 онд Төрийн өмчийн тухай хууль баталж, уг хуулийг хэрэгжүүлэх хугацаанд хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан 1948 оноос төрийн өмчийн талаарх багц хууль боловсруулан гаргажээ. Үүнд: 1) Төрийн өмчийн тухай хуулийн хууль (1948); 2) Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хууль (1955); 3) Эд зүйлсийн удирдлагын тухай хууль (1956) хамаарна.
8	“Нээлттэй нийгэм Форум” Д.Давааням (LL.D, Nagoya)	“Төрийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт” Бодлогын судалгаа, зөвлөмж ⁵⁸	Тус судалгааны хүрээнд Японы Улсын төрийн өмчийн харилцаа (бэлэн мөнгөнөөс бусад)-г зохицуулсан дараах голлох гурван хуульд анхаарал хандуулан авч үзжээ. 1) Төрийн өмчийн тухай хуулийн хууль (1948) 2) Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хууль (1955) 3) Эд зүйлсийн удирдлагын тухай хууль (1956)
9	Хууль зүйн ухааны доктор, Володягийн Болормаа	“Төрийн өмчийн тухай эргэцүүлэхүй” Эрдэм шинжилгээний нийтлэл, өгүүлэл ⁵⁹	Тус судалгааны ажлаар, “төрийн өмч” гэж ярих нь хэр оновчтой эсэх талаар эргэцүүлэн бодоход “төр”, “өмч” гэж чухам ямар ойлголт вэ? Өөр хоорондоо хэрхэн холбогдох “Төрийн” гэх харьяалуулсан томъёолол хэр оновчтой болох талаар хариулт эрэлхийлэх оролдлого хийсэн байна.

⁵⁸ Г.Давааням: Төрийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт (legaldata.mn)

⁵⁹ В.Оюумаа: Төрийн өмчийн тухай эргэцүүлэхүй (legaldata.mn)

10	Хуульч, судлаач Р.Лхагвабаяр	Байгалийн баялаг ашиглалттай холбоотой иргэний мэдэх эрх ба эрх зүйн шинэтгэл ⁶⁰	Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт байгалийн баялаг ашиглалттай холбоотой иргэний мэдэх эрхийг баталгаажуулсан заалтыг нэмэлтээр оруулсан. Гэвч манай улсын эрх зүйн тогтолцоонд энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нарийвчилсан зохицуулалтууд тусгагдсан эсэх, тэдгээрийг Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулж чадсан эсэх нь өнөөг хүртэл тодорхойгүй байх тул тус судалгааны ажлаар уг асуудлыг хөнджээ.
11	Судлаач, О.Хишигмөнх, Б.Досжан	Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах зарчмыг хэрэгжүүлсэн эсэх асуудал ⁶¹	Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хууль болон Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу хийж тухайн хуулиудад заасан зарчмуудыг мөрдлөг болгодог. Тэдгээр зарчмын нэг болох ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах зарчмыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийхэд хэрхэн баримталж баталсан эсэх талаар онол, хууль зүйн үндэслэл, хэрэгжихэд тулгамдсан зарим асуудлыг тодорхойлох, бусад улсын туршлагыг судлан үзэж дүгнэлт хийхийг зорьжээ.
12	Хуульч, судлаач Г.Оюундарь	Нам байгуулах шалгуурыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлтээр бүрдүүлсэн нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан эсэх талаарх	Арван ес ¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна” гэж нэмсэн заалт нь Монгол улс түүхэндээ анх удаа нам байгуулах шалгуурыг Монгол Улсын Үндсэн хуулиар бататган бэхжүүлсэн зохицуулалт болсон. Иймд уг судалгааны ажлаар “Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна”

⁶⁰ Р.Лхагвабаяр: Байгалийн баялаг ашиглалттай холбоотой иргэний мэдэх эрх ба эрх зүйн шинэтгэл (legaldata.mn)

⁶¹ О.Хишигмөнх Б.Досжан: Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: Ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах зарчмыг хэрэгжүүлсэн эсэх асуудал (legaldata.mn)

		судалгаа ⁶²	гэж заасан нь улс төрийн нам байгуулах шалгуур үзүүлэлт бөгөөд энэ нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан шинжтэй болохоос урьдчилан сэргийлж органик хуулиар зохицуулалт хийх шаардлагатай талаар судалгаандаа тусгажээ.
13	“Нээлттэй Нийгэм Форум” 2020 оны 5 сар №29 А.Бямбажаргал,	“Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаарх харьцуулсан шинжилгээ” ⁶³	Хууль тогтоогчид шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъектүүдийн уламжлалд тулгуурлах хандлагыг хамгаалж ирснээр шинэ үндсэн хуулийн суурь зарчим бүрэн хэрэгжих боломжгүй өнөөг хүрлээ. Үүний нэг тод илрэл нь Улсын дээд шүүх (УДШ)-ээс шүүн таслах үйл ажиллагаанд үл хамаарах буюу захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх явдлыг өмнөх тогтолцоонд (1925-1990) байснаар хадгалж ирсэн явдал юм. Энэхүү судалгаагаар уламжилж ирсэн энэхүү хамаарлыг арилгаж, улмаар ардчилсан шинэ үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын дагуу УДШ-ийн чиг үүргийг хуульчлах үндэслэлийг дэвшүүлэх болно.
14	МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Мөнхсайхан	“Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь” Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 он/Дугаар 4, Цуврал 79	Монгол Улсын Засгийн газар Шүүхийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж 2020.04.10-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Үүний зэрэгцээ 2020.04.23-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Шүүхийн тухай хууль болон Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай хуулийн төслүүдийг мөн өргөн мэдүүлсэн. Тус өгүүлэлд Засгийн газрын болон Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн дээрх төслийн заалт бүрийг нэг бүрчлэн үнэлж дүгнэх бус, харин шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан хариуцлагатай байдалд нөлөөлөх гол заалтуудыг сонгох авч анализ хийхийг зорьсон байна. Түүнчлэн тус бүтээлийг олон улсын сайн туршлага, дотоодод тулгарч байсан бэрхшээлээс авсан сургамжид

⁶² Г.Оюундарь: Нам байгуулах шалгуурыг Монгол улсын үндсэн хуулийн нэмэлтээр бүрдүүлсэн нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан эсэх талаарх судалгаа (legaldata.mn)

⁶³ Нээлттэй Нийгэм Форум: Улсын дээд шүүхийн чиг үүргийн талаарх харьцуулсан шинжилгээ (legaldata.mn)

			үндэслэн бичжээ.
15	Хуульч, судлаач П.Баттулга	“Монгол Улсын шүүхийн томилгооны системийг боловсронгуй болгох нь” ⁶⁴	Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4-т “Шүүхийн ерөнхий зөвлөл ... хуульчдаас шүүгчийг шилж олох үүргийг биелүүлэх”, Тавин нэгдүгээр зүйлийн 2-т “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно” гэж шүүгчийн томилгооны эрх зүйн үндсийг тогтоосон. Энэхүү өгүүллээр Монгол Улсын шүүхийн томилгооны системийн хүрээнд олон нийтийн итгэлийг унагааж буй асуудлуудыг тодруулж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаарх судалгааны үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмж боловсруулахыг зорьжээ.
16	Судлаач Р.Хатансайхан	Хот, тосгон талаарх 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал ба 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалыг харьцуулах нь, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 он/№3, Цуврал 83	1992 оны Үндсэн хуулийн дөрөвдүгээр бүлгээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай асуудлыг зохицуулсан бөгөөд уг бүлгийн агуулгад хот, тосгоны эрх зүй багтдаг. Гэвч хот тосгоны талаарх үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрхэн ойлгож, цаашид дэлгэрүүлэх вэ, хотыг эрх зүйн хувьд хэрхэн авч үзэх вэ гэдэг дээр өнөө хэр маргасаар байна. Хот, тосгоны үндсэн хуулийн үзэл баримтлалыг нэг мөр болгох нь иргэний, хүмүүнлэг, ардчилсан нийгмийг цогцлоох хот, тосгоны асуудлыг шийдвэрлэх хүрээнд эрх зүйн шинэтгэл хийх хөрс болох учиртай. Иймд, судлаач нь тус өгүүллээр 1992 оны үндсэн хууль болон 2019 оны үндсэн хуулийн хот, тосгоны үзэл баримтлалыг харьцуулан судалжээ.

⁶⁴ П.Баттулга: Монгол улсын шүүхийн томилгооны системийг боловсронгуй болгох нь/ Strengthening the judicial appointment system of Mongolia (legaldata.mn)

17	<p>Т.Мэндсайхан, МУИС-ийн ХЗС-ийн багш, Хууль зүй доктор, Б.Өлзийсайхан, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулийн захирал, хууль зүйн доктор</p>	<p>“Шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн шинэтгэл”, Үндсэн хуулийн эхийг баригч-Б.Чимид олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2020</p>	<p>Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд анх удаа төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн тусгаар, бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ шүүхийн захиргааны байгууллага, түүний чиг үүргийг тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлд “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана” гэж тусгасан юм. 2012 оны Шүүхийн тухай багц хуулиар шүүхийн захиргааны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба сүүлийн 6 жилд зарим эерэг өөрчлөлтийг бий болгожээ. Гэвч шүүхийн болон шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан хараат бус байдлын талаар багагүй шүүмж гарч, шүүгчийг шилж сонгох чиг үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн байдал болон шүүгчийн томилгооны журмыг Үндсэн хуулийн төвшинд дахин авч үзэх, өөрчлөх саналын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгагдаж, улмаар олон удаагийн хэлэлцүүлгийн явцад зарим нь дэмжигдэн батлагдаад байна.</p> <p>Тус илтгэлээр шүүх эрх мэдлийн шинэтгэл дэх шүүхийн захиргааны төлөвшил, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа, түүнийг үр нөлөөг танилцуулахыг зорьсон байна.</p>
18	<p>Г.Жаргал, Удирдлагын академийн Удирдлага, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор Я.Долгоржав, Удирдлагын Академийн төрийн удирдлагын тэнхимийн эрхлэгч,</p>	<p>“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь зохион байгуулалт, шийдвэр, түүхэн үечлэл, сургамж, хандлага”, Үндсэн хуулийн эхийг баригч-Б.Чимид олон улсын эрдэм шинжилгээний</p>	<p>Тус судалгааны хүрээнд, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг 1911-2019 онуудад зохион байгуулж ирсэн шийдвэр, түүний хэрэгжилтийг судалж, 1) Богд хаант Монгол Улсын засаг захиргааны шинэчлэл (1911-1921 он), 2) Ардын хувьсгалын дараах нутгийн захиргааны шинэтгэлийн эхэн үе (1921-1940 он), 3) Засаг захиргааны гурван төвшинд шилжсэн үе (1940-1959 он), 4) Нийгэм журмын үед нутгийг захиргааг аж ахуйн захиргаатай</p>

	доктор, профессор	хурлын эмхэтгэл, УБ., 2020	нэгтгэсэн өөрчлөлт (1960-1992 он), 5) Төрийн болон орон нутгийн удирдлагыг хослуулсан шилжилтийн үе (1992 оноос) гэсэн түүхэн 5 үе шатаар хувьсаж хөгжиж ирсэн байдлыг тодорхойлж, үе үеийн ололтыг тодотгож, сургамжийг бичсэн байсан. Шилжилтийн үед тулгамдсан олон асуудлын заримыг нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр (2019) хэрэгжүүлэх боломж нээгдсэнийг мөн авч үзлээ.
19	Судлаач Б.Мягмарсүрэн	Монгол Улсын Үндсэн хууль дахь Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх зохицуулалт ба хууль тогтоох байгууллагын оролцоог хязгаарлах механизмын зарим асуудал ⁶⁵	Энэхүү илтгэлээр Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх талаар онолын асуудлыг судалж, ХБНГУ болон Польш, Унгар, Чех зэрэг пост социалист орнуудын зохицуулалтуудыг судлан, сайн туршлага бүхий зохицуулалтуудыг илрүүлэх замаар МУҮХ-ийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр орсон зохицуулалтуудад дүн шинжилгээ хийж, дотоодын эрх зүйн тулгамдсан асуудлыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэсэн дүгнэлт, санал боловсруулахыг зорьжээ.
20	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн гэрээт багш, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт	ҮХНӨ: Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг юу вэ? ⁶⁶	ҮХНӨ-ийн төслийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэсэгт “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна” гэсэн хэсгийг тойрсон хэлэлцүүлэг өрнөж байгаа тул судлаач өөрийн саналыг тус бүтээлээр хүргүүлсэн байна. Ингэхдээ шүүх эрх мэдэл (ШЭМ) зохих ёсоор хэрэгжихийн тулд Шүүн таслах ажиллагаа (ШТА)-наас гадна, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хүний нөөцийг шилж сонгох, хэргийн хөдөлгөөний болон шүүхийн менежмент зэрэг асуудал цогцоороо шийдвэрлэгдэн ажиллаж байж үр дүнд хүрнэ. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр

⁶⁵ Б.Мягмарсүрэн: Монгол улсын үндсэн хууль дахь ерөнхий сайдад итгэл хүлээлгэх зохицуулалт ба хууль тогтоох байгууллагын оролцоог хязгаарлах механизмын зарим асуудал (legaldata.mn)

⁶⁶ Ц.Цогт: ҮХНӨ: Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг юу вэ? (legaldata.mn)

			зүйлд зааснаар “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах” зорилго бүхий, шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах чиг үүрэгтэй байгууллага учир түүний үйл ажиллагаа бүхэлдээ “шүүгч гагцхүү хуульд захирагдах, шүүх бие даан” ажиллах нөхцөлийг хангахад чиглэх ёстой тухай өгүүлжээ.
21	Хуульч, судлаач П.Баттулга	Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг үндсэн хуулиар тодорхойлсны ач холбогдол юу вэ? ⁶⁷	2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно” хэмээн өөрчлөн найруулсан. Энэхүү нийтлэлээр Үндсэн хуульд оруулсан уг нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдлыг тодорхойлохыг зорьжээ.
22	Судлаач Д.Энхтайван	Гүйцэтгэх эрх мэдэл ба шүүх эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн зарим асуудалд (захиргааны байгууллагын сонгох боломжийн хүрээнд) ⁶⁸	Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийгдэж буй эрх зүйн шинэтгэлийн шинэ үе шатанд шүүгчийн хариуцлагыг сайжруулах нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан хийх эрх зүйн шинэтгэл нь шүүгчийн хараат бус (хууль, хууль зүйн шинжлэх ухаанд тулгуурлан шударгаар хянан шийдвэрлэх), шүүхийн бие

⁶⁷ П.Баттулга: Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг Үндсэн хуулиар тодорхойлсны ач холбогдол юу вэ? (legaldata.mn)

⁶⁸ Л.Энхтайван: Гүйцэтгэх эрх мэдэл ба шүүх эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн зарим асуудалд (Захиргааны байгууллагын сонгох боломжийн хүрээнд) (legaldata.mn)

			<p>даасан байдлыг хангах явдалд чиглэх нь чухал билээ. Энэхүү судалгаагаар захиргааны байгууллагын сонгох боломж (шийдвэр гаргах орон зай)-д хэтрэн орсон зарим шүүхийн шийдвэр нь шүүх эрх мэдлийн зүгээс гүйцэтгэх эрх мэдэлд халдаж буй хэрэг тул эдгээр 2 эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн асуудлыг хөндөх замаар шүүгчийн мэргэжлийн хариуцлагын асуудлыг авч үзсэн болно.</p>
23	<p>Эрдэм шинжилгээний ажилтан Хууль зүйн үндэсний хүрээлэн Г.Дэжидханд</p>	<p>Шүүхийн сахилгын хороо, түүний бүрэлдэхүүн ба шүүгчийн хараат бус байдал⁶⁹</p>	<p>Монгол Улсын Үндсэн хууль бол шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлын төлөө хууль мөн. 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн юм. Нэмэлт, өөрчлөлтийн нэг томоохон хэсэг нь шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн гурван заалт бөгөөд энэ хүрээнд шүүхийн тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их хуралд өргөн мэдүүлээд байна. Уг хуулийн төслөөр одоогийн шүүхийн “Ёс зүйн хороо”-г шүүхийн “Сахилгын хороо” гэж өөрчлөн, эрх зүйн байдлыг шинээр тодорхойлжээ. Судлаачийн зүгээс Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөлд зааснаар шүүхийн “Сахилгын хороо”-ны бүрэлдэхүүнд Байнгын хороо, Ерөнхийлөгч болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс сонгогдсон болон томилогдсон төлөөлөл оруулах нь тохиромжтой /зүйтэй/ эсэх, энэ нь хэтдээ шүүх эрх мэдэл, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх эсэх асуудлыг сонгон энэхүү сэдвийг судалсан байна. Шүүгчийн хараат бус байдал алдагдахад дан ганц шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх тогтолцоо гажуудаад зогсохгүй нийгэмд хууль, шударга ёс алдагдаж үндсэн</p>

⁶⁹Г.Цэрэндэжид: Шүүхийн сахилгын хороо, түүний бүрэлдэхүүн ба шүүгчийн хараат бус байдал (legaldata.mn)

			<p>хуулийн байгуулал, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөнө. Тийм учраас шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал баталгаатайгаар хангагдаж байж хууль шударга ёс, ардчиллыг тогтоох үндсэн хуулийн зорилго биеллээ олдог байна. Иймд энэхүү судалгаагаар хөндсөн сэдэв нь шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахад хамаарал бүхий чухал ач холбогдолтой сэдэв гэж үзжээ.</p> <p>Судалгааны ажлын явцад олон төрийн санал, дүгнэлт бүхий материалаас түүврийн аргаар мэдээлэл цуглуулсан болно. Мөн гадаад орны жишиг, олон улсын эрх зүйн баримт бичгийг харьцуулан судалж үзсэн байна.</p>
24	Судлаач Р.Оюундэлгэр	Шүүхийн тогтолцоо дахь хууч хамаарал буюу шүүхийн нутаг дэвсгэрийн зарчмын хэв маяг, түүнийг халж Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх нь ⁷⁰	<p>1992 оны Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ” гэсэн зохицуулалт нь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хөндөгдөөгүй бөгөөд харин ч “...шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно” гэсэн заалт нэмэлтээр батлагджээ. Энэхүү хэм хэмжээ нь шүүх байгуулахдаа нутаг дэвсгэрийн хувьд тойргийн зарчмаар бүсчлэн байгуулах зохицуулалт болсон хэдий ч Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоог шүүхийн нутаг дэвсгэрийн зарчмаас салгалгүй хэвээр үлдээсэн. Иймд, тус судалгааны ажлаар шүүхийн үндсэн тогтолцоонд шүүхийн нутаг дэвсгэрийн зарчмыг хуульчлан баталгаажуулсан нь:</p> <p>1)шударга шүүхээр шүүлгэх, давж заалдах эрхийг баталгаатай эдлүүлэхэд шүүхийн үндсэн тогтолцооны шаталсан шүүхийн зарчмыг бүдгэрүүлж, 2)захиргааны байгууллагын нэгдмэл</p>

⁷⁰ Р.Оюундэлгэр: Шүүхийн тогтолцоо дахь хууч хамаарал буюу шүүхийн нутаг дэвсгэрийн зарчмын хэв маяг, түүнийг халж үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх нь (legaldata.mn)

			зарчимтай адил хэсгийг хуульчилснаараа шатлал хоорондын эрх мэдэл хуваарилалтын алдагдуулсан зэрэг асуудлыг хөндөх замаар шүүхийн үндсэн тогтолцоо, түүн доторх шаталсан шүүхийн дотоод эрх мэдэл хуваарилалтын талаарх асуудлыг уг илтгэлд авч үзжээ.
25	Судлаачид Б.Лхагважаргал, Х.Норовсүрэн	Нутгийн өөрөө удирдах байгууллагын хараат бус, бие даан шийдвэр гаргах эрхийг үндсэн хуулиар хамгаалах нь ⁷¹	Монгол улс 1992 онд анхны ардчилсан үндсэн хуулиа баталж, зах зээлийн нийгэмд хөл тавьсан ба анх удаа нутгийн өөрөө удирдах ёсыг сонгодог утгаар нь хэрэгжүүлэх үндэс суурийг тавьсан. Нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлснээрээ хэт төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэх гэх мэт олон давуу талтай бөгөөд уг ойлголт нь Монгол улсын үндсэн хуулийн 57-63 дугаар зүйлүүдэд тусгалаа олсон байдаг. Цаашлаад, 2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсийг улам бэхжүүлсэн байна. Ийнхүү нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд бие даан шийдвэр гаргах эрхтэй гэж үндсэн хуульд тусгагдсан хэдий ч Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Захиргааны ерөнхий хуульд “хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах” эрхтэй байхаар хуульчилсан. Ингэхдээ ердийн хуулиар тусгайлан эрх олгосон байхыг шаардаж, нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байгаа нь хэт явцуу хүрээнд тайлбарласан хэрэг бөгөөд үндсэн хуулиар хамгаалсан нутгийн өөрөө удирдах ёсыг хязгаарлаж байна.

⁷¹ Б.Лхагважаргал, Х.Норовсүрэн: Нутгийн өөрөө удирдах байгууллагын хараат бус, бие даан шийдвэр гаргах эрхийг үндсэн хуулиар хамгаалах нь (legaldata.mn)

			Харин Япон улсын хувьд заавал ердийн хуульд тусгайлан заахыг шаардахгүйгээр, ердийн хуулийн хүрээ хязгаар нь үндсэн хуулийн хүрээ хязгаараар тодорхойлогдоно гэж үзэж, үндсэн эрх болон зарчмуудыг илүү өргөн хүрээгээр тайлбарлаж, үндсэн хуулийн хамгаалалтыг хэрэгжүүлж байна. Иймээс тус илтгэлийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даан шийдвэрлэх эрх хэмжээг ердийн хуулиар бус Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хязгаарлах хэрэгтэй гэж үзжээ.
26	Улс төр судлаач, Э.Сундуй,	Засгийн газрыг байгуулахад эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцэл үйлчилж байгаа эсэхэд хийсэн шинжилгээ, Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Үндсэн хууль ба эрх зүйн ёс-ХИ” (Шилдэг илтгэлийн эмхэтгэл), УБ., 2021	2019 оны 11-р сарын 14-нд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрыг байгуулахад хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хооронд эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцэл хангагдах нөхцөл хэрхэн нөлөөлсөн бэ? Тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь улс төрийн ямар үйл явц, нөлөөлөл үзүүлэхийг Монгол Улсын өнгөрсөн түүх, бусад улсын жишээгээр тайлбарлахад судалгааны зорилго чиглэжээ.
27	Эрдэм шинжилгээний ажилтан Хууль зүйн үндэсний хүрээлэн Д.Дэмидханд	Төрийн өмчийн эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал ба үүнийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх нь Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Үндсэн хууль ба эрх зүйн ёс-	2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс мөрдөгдөж буй Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 6.2 дахь зүйлийг өөрчлөн найруулснаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох харилцааг Үндсэн хуульд нийцүүлэх асуудал зайлшгүй үүссэн болохыг тус судалгааны хүрээнд авч үзсэн байна.

		XII” (Шилдэг илтгэлийн эмхэтгэл), УБ., 2021	
28	Судлаач оюутан 3.Сийлэгмаа	Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт ба эрх зүйн шинэчлэл ⁷²	Манай улсын улс төрийн санхүүжилтэд холбогдох хууль тогтоомжоор бол улс төрийн намууд санхүүжилтийн асуудлаа хариуцаж ирсэн бөгөөд төрөөс санхүүжүүлж байгаа мөнгөн дүн намын нийт санхүүжилтэд огтхон ч нөлөө үзүүлдэггүй. Ийм учраас улс төрийн намууд бизнесээс өрсөлдөж мөнгө босгодог, сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулаагүй, тайлагнаагүй “дэнчин” буюу нэр дэвших босго мөнгө зэргийг тогтоодог болоод байгаа билээ. Манай Монгол улс Энэтхэг, Тайланд, Индонез, Непал, Казахстан, Камбож гэх мэт улсууд хувийн корпорацаас хандив авахыг зөвшөөрдөг бол эсрэгээрээ хориглодог улс хэд хэд байдаг. Үүнээс дурдвал: Бутан, Афгинастан, Азейр-бажан, Жоржиа, Япон, Бүгд найрамдах Солонгос улс гэх улсууд байдаг. Эдгээр улсууд нь хувийн корпорацаас улс төрчдийг ангид байлгаснаар улс төрд бохир мөнгө орж ирэхээс зайлсхийж байна гэж үздэг. Иймд, тус судалгааны ажлын хүрээнд, сонгуулийн санхүүжилтийг хянах буюу ил тод байдлын асуудлыг авч үзжээ.
29	Улсын Бага Хурлын гишүүн, УИХ-ын гишүүн асан, Үндсэн хууль судлаач Ц.Товуусүрэн	Үндсэн хуулиа ойлгохуй Үндсэн хуулийн хялбаршуулсан тайлбар, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зүйл, заалтаар баяжуулж, шинэчлэн	Тус судалгааны бүтээлд Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг, зургаан бүлэг, 70 зүйл, 169 хэсэн, зарим хэсэг нь цааш задарч 72 заалтаас бүрдэж байгаа бөгөөд нийт хэсгийн болон хэсгийн доторх заалтыг нийцүүлбэл 241 заалт байгааг нэг бүрчлэн тайлбарлахыг оролдсон байна. Мөн зарим заалтад байгаа шууд ойлгоход бэрхшээлтэй уг хэллэгийг нь ч бас хэрхэн ойлгох талаар тайлбарлан бичжээ. Тус бүтээлд зохиогч өмнө нь эрдэмтэн мэргэдийн туурвисан

⁷² 3.Сийлэгмаа: Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт ба эрх зүйн шинэчлэл (legaldata.mn)

		боловсруулсан хоёр дахь хэвлэл ⁷³	бүтээлүүдийн санааг энгийн олон түмэнд ойлгомжтой хүрэхэд анхаарсан байна.
30	Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, Нээлттэй нийгэм форум, Г.Цагаанбаатар, Ж.Алтансүх, С.Батбаяр	“Шүүхийн тогтолцоо, тойргийн болон дагнасан шүүх”, бодлогын судалгаа, ⁷⁴	Тус судалгааг гүйцэтгэхдээ гадаад орны туршлагатай харьцуулан судлах, түүхчлэх, мөн Хууль тогтоомжийн тухай хуульд тусгагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах, урьдчилан тандаж үзэх зэрэг арга зүйг ашиглан дараах агуулгын хүрээнд судлан, бодлогын хувилбар дэвшүүлэхийн зорьжээ. Судалгаагаар анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар, дагнасан хэлбэрээр байгуулах хамгийн боломжит хувилбарыг санал болгох, зөвлөмж боловсруулах, судалгааны үр дүнд тулгуурлан газрын зураглал (инфографик зураг) боловсруулахаар төлөвлөж байна. Түүнчлэн дагнасан шүүх, тойргийн шүүх, тусгай шүүх зэрэг нэр томъёоны хэв шинжүүдийг тодорхойлж, нэг мөр болгох, дагнасан шүүхийн давуу болон сул талыг тодорхойлох, цаашид (ойрын хугацаанд) манай улсад ямар хэлбэрийн дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлага байгаа талаар дүгнэлт зөвлөмж гаргасан байна.
31	МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Мөнхсайхан	“Монгол улсын Шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал” эрх зүйн шүүмж ⁷⁵	Судлаач нь Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас дээр 2020.01.31-ний өдөр нийтэлсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төслийг судалсны үндсэн дээр санал боловсруулжээ. Энэхүү саналдаа уг төслийн заалт бүрийг нэг бүрчлэн үнэлж, дүгнэх бус, харин шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан, хариуцлагатай байдалд нөлөөлөх гол заалтуудыг сонгон авч, олон улсын сайн туршлага, дотоодод тулгарч байсан бэрхшээлээс авсан сургамж, өмнө нь хийж байсан судалгаанууддаа үндэслэн

⁷³ “Үндсэн хуулиар ойлгохуй” Ц.Товуусүрэн., УБ, 2020 он

⁷⁴ Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх, С.Батбаяр: Шүүхийн тогтолцоо: Тойргийн болон дагнасан шүүх (legaldata.mn)

⁷⁵ Хууль зүйн судалгааны бүтээлийн Цахим сан (legaldata.mn)

			<p>анализ хийхийг зорьсон байна. Энэ санал нь (1) Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, (2) Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо, (3) Шүүхийн хараат бус, бие даасан байдал, (4) Шүүгчийн сахилгын зөрчил ба шийтгэл, (5) Шүүхийн сахилгын хороо, (6) Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн үндсэн бүлгээс бүрдсэн.</p>
32	<p>МУИС-ийн хууль зүйн сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, А.Бямбажаргал,</p>	<p><i>“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт ба засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэтгэл”⁷⁶</i></p>	<p>2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн IV бүлэг болох “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага”-г орсон 2 зүйл, 3 заалт бүхий нэмэлт, өөрчлөлт нь бүхэлдээ тус бүлэг дэх 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалыг тодруулах зорилгоор хийгдсэн хэмээн үзэж болно. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд нутгийн удирдлагын эдийн засгийн эрхийг нэмэгдүүлэх чиглэлээр голлох нэмэлт, өөрчлөлт орсон. Үүнд: 1) Орон нутгийн өмч, орон нутаг өөрөө тогтоож болох шаардлагатай татварыг бий болгох, одоо хэрэгжиж буй асуудлыг дахин тодруулах боломжийг бий болгосон. 2) Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 2 дугаар зүйлд заасан зохицуулалтуудтай хамтад нь хэрэглэх шаардлагатай. 58 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй холбогдох шаардлага нь “аймаг, нийслэл, сум, дүүрэг” нь хуулиар тусгайлан чиг үүрэг бүхий, өөрийн удирдлага бүхий эдийн засаг, нийгмийн бие даасан “субъект” байх үндэс нь түүний онцлогоос хамааран “чиг үүрэг”, “төсвийн харилцаа” ялгамжтай байхыг баталгаажуулсан. 3) Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлтийн дагуу хот, тосгон өөрийн удирдлагаа зохион байгуулах хууль зүйн боломжийг нэгэнт бүрдүүлж байна. Иймд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,</p>

⁷⁶ “Шүүх эрх мэдэл” сэтгүүл., УБ, 2020 он №1

			түүний удирдлагын тухай”, “Хот, тосгоны эрх зүйн байдлын” тухай зэрэг органик хуулиудыг шинэчилсэн найруулгын хүрээнд батлахдаа дээрх үзэл баримтлалыг энэ тэргүүнд харгалзан үзэх шаардлагатай.
33	Удирдлагын академийн багш, Д.Сүнжид	<i>“Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба нутгийн удирдлага”⁷⁷</i>	Уг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өнөөдрийг хүртэл хэрэгжүүлэхэд бэрхшээл буюу тодорхойгүй байдал үүсгэж байсан асуудлыг шийдвэрлэх, ахисан төвшинд гаргахын тулд илүү тодруулж, нарийвчилсан зохицуулалт оруулсан нь ач холбогдолтой. Энэ салбарт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, эсхүл магадгүй Аймгийн тухай хууль, Нийслэлийн тухай хууль, Дүүргийн тухай хууль, Сумын тухай хууль, Хорооны тухай хууль, Багийн тухай хууль, Орон нутгийн өмчийн тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг бусад олон хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн явцад тулгамдсан асуудал болгон байнга дурдагдаж байсан асуудал орон нутгийн төвшний “улс төржилт” байсан бөгөөд орон нутгийн бичил улс төржилтөөс ангид байх асуудал нь улс төрийн нам болоод бусад сонгуулийн тухай хууль зэргээс хамаарна.
34	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, судлаач, Ж.Алтансүх	<i>“Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ба Ерөнхийлөгчийн бүрэн эрх</i>	2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хөндсөн 4 чухал өөрчлөлтийг хийсэн. 1) Улсын их Хурлын хариуцлагажуулахад чиглэсэн өөрчлөлт, 2) Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн гэх бэлгэдлийн шинж чанартай байх агуулгыг бататгахад чиглэсэн өөрчлөлт, 3) Шүүх эрх мэдлийг Ерөнхийлөгчөөс хараат бус байлгахад чиглэсэн өөрчлөлт, 4) Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлахад чиглэсэн өөрчлөлт зэрэг байна. Үүнээс Ерөнхийлөгчийн бүрэн эрх, чиг үүргийг

⁷⁷ “Шүүх эрх мэдэл” сэтгүүд, УБ, 2020 он №1

			<p>хязгаарлах агуулгаар дараах хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ. 1) Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар “Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаартай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах”, 2) Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан батлах, үүнд Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацаатай холбоотой зохицуулалтыг тусгах, 3) Бусад холбогдох хуульд “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрх олгох асуудлыг Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх” гэж төлөвлөжээ.</p>
35	Эрх зүйч, Д.Батболд	<p><i>“Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дэх Парламентын хянан шалгах эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалт”⁷⁸</i></p>	<p>Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Монгол улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад дараах байдлаар парламентын хянан шалгах эрх хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан байна. Монгол улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна” гэж хуульчилжээ. Зохицуулалтын агуулгаас харахад: - Нийтийн ашиг сонирхол хөндсөн асуудлаар; - Улсын Их Хурлын 19 гишүүн буюу дөрөвний нэгээс доошгүй гишүүд; -Хянан шалгах түр хороо байгуулах санал гаргавал Улсын Их Хурлын цөөнхийн төлөөллийг оролцуулан хянан шалгах түр хороо байгуулах хууль зүйн шаардлагыг тусгасан. Ийнхүү Үндсэн хуульд парламентын хянан шалгах эрх хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг хуульчилснаар парламентын хяналт</p>

⁷⁸ “Хууль дээдлэх ёс” Цуврал 78, УБ, 2020 он

			<p>явуулдаг арга хэрэгслээс хамгийн өргөн эрх хэмжээ бүхий үр нөлөөтэй хяналтын арга хэрэгслийг бий болгож, түүнд үндэслэн Улсын Их Хурал нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах чиг үүргээ хянан шалгах түр хороогоор дамжуулан хэрэгжүүлэх эрх зүйн боломж нээгдсэн байна.</p>
<p>36</p>	<p>Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн, Эрдэм шинжилгээний ажилтан, О. Төрболд</p>	<p><i>“Хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарын зарим асуудал”⁷⁹</i></p>	<p>2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно” хэмээн хуульчилсан. Уг нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулах Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 38 дугаар зүйлд хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарын талаар зохицуулсан. Тус зүйлд Засгийн газар ямар хууль хэрхэн санаачлах, Ерөнхийлөгч хууль санаачлахдаа юу баримтлах, Улсын Их Хурлын гишүүний санаачлах хууль зэргээр тогтоож өгсөн. Гэвч дийлэнх улсын Үндсэн хуульд хууль санаачлах эрхтэйгээр холбоотойгоор хүрээ, хязгаарын асуудлыг тусгаж өгөөгүй бөгөөд цөөн тооны улс Үндсэн хуульдаа энэ асуудлыг зохицуулдаг. Дийлэнх улс Үндсэн хуульдаа хууль санаачлах эрх бүхий субъектээр ерөнхийлөгч, парламент, засгийн газар, ард түмэн байхаар тодорхойлсон хэдий ч хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарын талаар дурдаагүй. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хууль санаачлах хүрээ, хязгаар гэх хэсэгт Ерөнхийлөгч болон Засгийн газрын хууль санаачлах эрхийг тодорхойлсон байгаа нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зорилттой нийцэхгүй байх тул Засгийн газрын хууль санаачлах эрхийг холбогдох Монгол улсын Засгийн</p>

⁷⁹ “Шүүх эрх мэдэл” сэтгүүл., УБ, 2021 он №1

			<p>газрын тухай хуулиар, Ерөнхийлөгчийн хууль санаачлах хүрээ, хязгаартай холбоотой зохицуулалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэг бүрчлэн тусгах шаардлагатай байна.</p>
<p>37</p>	<p>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн, нарийн бичгийн дарга, Хууль зүйн доктор П.Амаржаргал</p>	<p><i>“Хууль тогтоох эрх мэдлийн Үндсэн хуулийн шинэтгэл”⁸⁰</i></p>	<p>Ард түмний нийтлэг хүсэл зоригийг төлөөллийн байгууллагаас илэрхийлэх үндсэн хэлбэр нь хууль тогтоох үйл ажиллагаа бөгөөд хууль тогтоох нь хууль тогтоох эрх мэдлийн амин сүнс. Хууль тогтоох эрх мэдлийн тухай үзэл баримтлал нь олонхын эрх ашгийн төлөө төрийн буюу эзэн хааны хэмжээгүй эрх мэдлийг хязгаарлах үзэл санаатай хамт хөгжиж ирсэн. Улсын их хурал нь ард түмний төлөөллийн байгууллага болохынхоо хувьд хууль батлах дээд эрх мэдэлтэй гэсэн утгаар нь Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийг зөвтгөн тайлбарлах гэсэн санааг энэ хэсэгт дэвшүүлж байгаатай холбоотойгоор 25 дугаар зүйлийг заавал хөндөх шаардлага үүсэж байна. Хорин тавдугаар зүйлд улс орны дотоод гадаад бодлогын аль ч асуудлыг хэлэлцэнэ гэж заасан. Хууль нь хүн төрөлхтний хөгжлийн олон үе шатыг дамжин бидэнд өвлөгдөхдөө “ард түмний эсхүл олон нийтийн зөвшилцөл” гэсэн утгаар ойлгогдох болсон учраас “хууль”-ийг ард түмэн “тогтооно”, харин нэгэнт тогтсон хуулийг Улсын их Хурал “батална” гэдэг ухамсар Монголд бүрэн төлөвшөөгүй. Уг үүднээс 25 дугаар зүйлийн 1 дэх заалтын “ямар ч асуудлыг хэлэлцэнэ” гэдгийг дараа 18 бүрэн эрх хууль тогтоох, угтаа хууль батлах эрх мэдэлтэй холбон тайлбарлах хэрэгтэй. Парламент нь өөртөө 25 дугаар зүйл дээр илүү бүрэн эрхийн асуудлаа тодруулж өгсөн. Угтаа парламент нь хууль батлах эрх мэдлийн байгууллага гэж илүүтэй авч үзэх нь чухал бөгөөд тус ойлголтыг бүрэн тайлбарлахгүйгээр хууль тогтоох үйл</p>

⁸⁰ “Үндсэн хуулийн эхийг баригч - Б.Чимид” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл., УБ, 2020 он

			ажиллагааны журам, шалгуур, хязгаарлалтын талаар ярих нь зохимжгүй.
38	Судлаач Б.Тогмидсүрэн	<i>“Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал ба Үндсэн хуулийн цэцийн оролцоо”⁸¹</i>	2019 оны 11 сарын 14-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 19 зүйл, 36 заалтад нэмэлт өөрчлөлт оруулсан. 2019 оны 6 сарын 6 -ны өдөр Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийн төслийг Үндсэн хуулийн цэцэд өргөн барьж Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох саналаа УИХ-д ирүүлэхийг уламжилсан. Үүнд Үндсэн хуулийн цэц дараах хариуг өгсөн байна. “Үндсэн хуулийн цэц эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг УИХ-д өргөн мэдүүлэхгүй болно. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалын агуулгад бүрэн нийцсэн байвал зохино”. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд Үндсэн хуулийн цэцээс ирүүлсэн саналыг нэг болон хоёр, гурав дахь хэлэлцүүлгээр оруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна. Үндсэн хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хэрэгжүүлэх үүднээс Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг уламжлан, санал авч, УИХ-ын хэлэлцүүлгээр заавал хэлэлцэх шаардлагатай. Энэхүү Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн цэцийн саналыг оруулах, хэлэлцүүлэх болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмыг өөрчлөлгүй, үүндээ Үндсэн хуулийн цэцийн байр суурийг хангаагүй байна.

⁸¹ “Үндсэн хууль ба эрх зүйт ёс ХР” Илтгэлийн эмхтгэл, УБ, 2020 он

3.2. Монгол улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн талаарх гадаадын эрдэмтдийн байр суурь

Хүснэгт 17: Гадаадын сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлийн жагсаалт

ГАДААДЫН СЭТГҮҮЛД ХЭВЛЭГДСЭН БАЙДАЛ			
№	Судлаач	Судалгааны нэр	Агуулга
1	МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, О.Мөнхсайхан:	“Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн урт, олон нийтийн оролцоотой зам” ⁸²	Профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан нь энэхүү нийтлэлээр Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан “2019 оны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явц нь хууль ёсны байдлыг нэмэгдүүлж, шинээр гарч ирж буй улс төрийн конвенцыг бий болгох шинэлэг, урьд өмнө байгаагүй олон нийтийн оролцоот үйл явцыг хамарсан. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн шинэчлэл нь засгийн газрын тогтвортой байдал, хариуцлага, шүүхийн хараат бус байдал, орон нутгийн үр ашигтай засаглал, нөөцийн тэгш менежментэд хувь нэмэр оруулах магадлалтай. Гэсэн хэдий ч нэг л ойлголт, зөвшилцөлд тулгуурлан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дөчин тав гаруй хууль батлагдах, батлагдан гарах үйл явцаас их зүйл шалтгаална. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлгийн явцад эх баригч намаар МАН ажиллаж байсан ч олон нийт, гол сөрөг хүчин болон Ерөнхийлөгч зэрэг олон талыг оролцуулан зөвшилцсөн. Мөн иргэдийн оролцоог хангах үндсэн дээр туршилтын санал асуулгыг улс орны өнцөг булан бүрээс санамсаргүй түүврээр сонгогдсон иргэдээс санал авч үр дүнд нөлөөлөх боломжийг олгосон” хэмээжээ. Цаашлаад нийтлэлийн бүтцэд - Боломжгүй улс төрийн элит ба

⁸² Munkhsaikhan Odonkhoo “Mongolia’s Long, Participatory Route to Constitutional Reforms”, [Mongolia’s Long, Participatory Route to Constitutional Reforms | ConstitutionNet](#) [Сүүлд үзсэн: 2022 оны 3 сарын 16]

	<p>МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, О.Мөнхсайхан:</p>	<p>“Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн урт, олон нийтийн оролцоотой зам”⁸³</p>	<p>иргэний нийгмийн зөвшилцөл</p> <ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох эрх мэдлийн харилцааг шинэчлэн тогтоох, тэнцвэржүүлэх - УИХ-ын сонгууль, улс төрийн намууд - Нэг удаагийн ерөнхийлөгчийн засаглал - Шүүгчийн хараат бус байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх - Хотын засаглалыг сайжруулах - Байгалийн нөөцийг ашиглах үндсэн зарчмуудыг тодорхойлох гэсэн дэд хэсгүүдэд хуваагдаж 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг бүлэг тус бүрээр дүгнэн тайлбарлажээ. <p>Нийтлэлийн дүгнэлтээр “1992 оны Үндсэн хуулийг 15 сарын турш олон нийтийн оролцоотой, хэлэлцүүлгийн явцад баталсан бол 2000 онд Үндсэн хуульд оруулсан анхны нэмэлт, өөрчлөлтийг олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр хаалттай хэлэлцэж баталсан түүхтэй. 2011, 2012, 2015 онуудад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах оролдлого бүтэлгүйтсэн нь ч мөн адил нээлттэй бус байсан. Энэхүү туршлагаас харахад 2016-2019 оны хооронд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцад иргэд, эрдэмтэн судлаачдын оролцоо, улс төрийн оролцогчдын зөвшилцлийг бий болгох нь чухал байсан. Төсөлд анх орсон зарим заалтыг орхигдуулсан ч батлагдсан нэмэлт, өөрчлөлтөд Засгийн газрыг тогтвортой, үр ашигтай болгох, парламентыг илүү мэргэшсэн, шүүхийг хараат бус, хариуцлагатай болгох, ерөнхийлөгчийн хязгаарлалттай, улс төрийн намууд илүү ардчилсан, санхүүгийн хувьд ил тод, орон нутгийн засаглал илүү үр</p>
--	---	---	---

⁸³ Munkhsaikhan Odonkhoo “Mongolia’s Long, Participatory Route to Constitutional Reforms”, [Mongolia’s Long, Participatory Route to Constitutional Reforms | ConstitutionNet](#) [Сүүлд үзсэн: 2022 оны 3 сарын 16]

			ашигтай, байгалийн баялгийн бодлого нь ард түмэнд илүү ашигтай болсон. Гэхдээ нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай дөчин тав гаруй хуулийн төслийг боловсруулж, хэрэгжүүлэх эсэхээс их зүйл шалтгаална” хэмээжээ.
2	Хууль зүйн доктор, Володягийн Болормаа	“Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт” нийтлэл ⁸⁴	Энэхүү нийтлэлээр Монгол Улсын 1992 оны ардчилсан шинэ Үндсэн хуулийн танилцуулж 1992 оны Үндсэн хууль нь 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудаас илүү хүний эрх, эрх чөлөөг хамгаалан тодотгож тусгасан онцлогтой гэдгийг дурджээ. Цаашлаад Монгол Улсын Их Хурал 2019 оны арван нэгдүгээр сарын 14-ний өдөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталсан бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны долдугаар сарын 1-ний өдрөөс буюу УИХ-ын сонгуулийн дараа дагаж мөрдөх тухай тайлбарлажээ. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дараах агуулга бүхий нэмэлт өөрчлөлт орж буйг нийтлэлд хүснэгт хэлбэрээр оруулжээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө; - Улсын Их Хурал (УИХ) - Гүйцэтгэх салбар; - Шүүх эрх мэдэл; - Орон нутгийн засаглал.
3	Судлаач, Independent political analyst, Melbourne School of	“Монголд Үндсэн хуульд ардчилал яагаад аюулд оров” нийтлэл ⁸⁶	Энэхүү нийтлэлээр судлаач А.Бат-Оргил Монгол улсын 1992 оны шинэ ардчилсан Үндсэн хуулийн тухай анхлан дурдаад сүүлийн 30 жилийн туршид хийгдсэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт тус бүрийн ач холбогдол, сул тал цаашлаад Коронавируст (Ковид-19) цар тахлын үеийн УИХ болон

⁸⁴ Bolormaa Volodya “Mongolia: The Amendment On Constitution Of Mongolia” article by GRATA International [The Amendment On Constitution Of Mongolia - Government, Public Sector](#), [Сүүлд үзсэн 2022 оны 3 сарын 16]

⁸⁶ “The Price of Limiting Power Why Constitutional Democracy in Mongolia is in Danger”, Bat-Origl Altankhuyag, <https://verfassungsblog.de/the-price-of-limiting-power/>

	<p>Government at the University of Melbourne.\ Бат-Оргил Алтанхуяг⁸⁵</p>		<p>Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулсан болохыг цохон тэмдэглэжээ. Цаашлаад 2000 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан “Дордуулсан долоон өөрчлөлт”-өөс - 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хүртэл гэсэн хэсгээр “Стэнфордын их сургуулийн профессор Фишкиний зөвлөсөн ардчиллын арга барилыг ашиглан үндсэн хуулиа өөрчилсөн цөөхөн орны нэг нь Монгол болсон. Нэмэлт өөрчлөлт оруулахдаа зөвлөлдөх санал асуулгын аргаар Засгийн газар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар иргэдийн санал бодлыг судлахыг оролдсон. Хэдийгээр энэ үйл явц нь төлөөллийн түүвэрлэлтийн арга ашиглаж хийгдсэн гэж мэдэгдэж байсан ч энд залилан, хууран мэхлэлт хийгдсэн байх боломжтой. Тухайлбал, зарим иргэдэд тэнцвэргүй мэдээлэл өгч, өрөөсгөл асуулт тавьсан байжээ”. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараагийн голлох санал нь ард түмнээс сонгогдсон ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлаж, ерөнхий сайдад, ялангуяа Засгийн газрын гишүүдийг сонгоход илүү эрх мэдэл олгосон явдал байсан. Нэмэлт өөрчлөлт оруулсны дараа эдгээр хоёр байгууллагын хооронд зөрчил гарна гэж олон эрдэмтэд хүлээж байсан. Энэ хүлээлт нь тухайлбал, ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг шинэчилсэн хязгаарлалттай холбоотой. Өмнө нь Үндсэн хуульд бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил, 2 удаа сонгогдох боломжтой байхаар заасан байсан бол нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нэг удаа зургаан жилээр болгож хязгаарласан. Анх энэ заалтыг 2025 оноос хойш хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан ч энэ хугацааг цуцалсан. Үүний үр дүнд улстөрчид болон хуульчдын дунд шинэ хугацааны</p>
--	---	--	---

⁸⁵ “An orchestrated presidential election in Mongolia3” article by Research Bat-Orgil Altankhuyug, 15 Jul 2021 <https://electionwatch.unimelb.edu.au/articles/an-orchestrated-presidential-election-in-mongolia>

			<p>хязгаарлалт одоогийн Ерөнхийлөгчид хамаарах эсэх талаар маргаан үргэлжилсэн. Удаан ярилцсаны эцэст сөрөг хүчний зарим гишүүд энэ асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандсан. Үндсэн хуулийн цэцээс одоогийн болон хуучин Ерөнхийлөгчид дахин Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших боломжгүй гэсэн шийдвэр гаргасан” тухай өгүүлжээ. Цаашлаад 2019 онд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсон ч ойлгомжгүй, хүндрэлтэй асуудлууд байсаар байна. Үүнд: Нэгдүгээрт нэмэлт өөрчлөлтөөр ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийн хүч, эрх мэдэл сайжраагүй. Ерөнхийлөгчтэй харьцуулахад Ерөнхий сайдын хууль ёсны эрх мэдэл сайжирсан. Шүүгчид улс төрийн нөлөөнд автсан хэвээр байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц өөрчлөгдөөгүй. Нийтлэлийн дүгнэлт хэсэгт “Хэдийгээр сүүлийн нэмэлт өөрчлөлт нь манай ардчилалд эерэг өөрчлөлт болсон гэдэгтэй улс төрчид санал нэгдэж байгаа ч сүүлийн өөрчлөлт төдийлөн хол явж чадаагүй гэж би үзэж байна. Улс төрийн тогтворгүй байдал ийм хэмжээнд үргэлжилбэл Монголын улс төрийн хямрал үндсэн хуульд ардчиллын институцийг аюулд оруулж болзошгүй” хэмээжээ.</p>
4	P. Amarjargal, Ph.D., Scientific Secretary, the National Legal Institute of Mongolia	Constitutional Reform of the Legislative Authority, Mongolian law journal, 2020 No.5, Series 80	<p>Судлаач Р.Амаржаргал нь энэхүү нийтлэлдээ “Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш аль хэдийн хорин найман жил болж, парламентын засаглалд шилжээд байна. Хууль тогтоох байгууллагын онол, мөн чанар, гарал үүсэл нь судлагдсан боловч асуудлууд байсаар байна. Хууль тогтоох эрх мэдлийн тухай ойлголтыг өнгөрсөн хугацаанд эрдэмтэд янз бүрээр тайлбарлаж ирсэн ч эрх зүйн философийн хүрээнд авч үзэх шаардлагатай юм” хэмээжээ. Цаашлаад энэ нийтлэлийн агуулга нь Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдлийн мөн чанар, онол, үзэл</p>

			баримтлал, хэлбэр, ангилал, хязгаарлалт, хууль тогтоох дээд эрх мэдэл хязгаарлагдмал эсэх талаар дүгнэлт хийх, УИХ-ын хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хуулийн заалт, зохицуулалтад хэрхэн туссан болохыг тодорхойлохыг оролдсон байна.
5	GRATA INTERNATIONAL Олон улсын судалгааны байгууллага	“Эрх зүйн шинэчлэл: Монгол Улсын Үндсэн Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай” Legal update: The Amendment on Constitution of Mongolia ⁸⁷	Тус нийтлэлд “Монгол Улсын шинэ Үндсэн хууль 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр баталж, 1999, 2001 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан социалист нийгмээс Ардчилсан нийгэмд шилжсэн хувьсгалын дараа төлөөллийн ардчиллыг бий болгосон. Үндсэн хуульд оруулсан хамгийн сүүлчийн нэмэлт, өөрчлөлтөөр тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөө, төрийн бүтэц, түүний дотор Улсын Их Хурал, Засгийн газар, Шүүх эрх мэдлийн байгууллага, НИТХ, Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар дор дурдсан зүйлд шинэ заалтуудыг тусгажээ. Энэхүү 1992 оны шинэ ардчилсан Үндсэн хууль нь өмнөх 1924, 1940, 1960 онд батлагдсан Үндсэн хуулиудаас илүү хүний эрхийг хамгаалах зорилгоор батлагдсан бөгөөд 1992 оны Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталсан байна. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны долдугаар сарын 1-ний өдрөөс буюу УИХ-ын сонгуулийн дараа дагаж мөрдөнө. Энэ дараах агуулга бүхий бүлгүүд нэмэлт өөрчлөлт орж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тусгаар тогтнол ба хүний эрх, эрх чөлөө - УИХ - Гүйцэтгэх эрх мэдэл - Шүүх эрх мэдэл - Орон нутгийн засаглал зэрэг байна” хэмээгээд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр батлагдсан зүйл

⁸⁷ GRATA International “Legal update: The Amendment on Constitution of Mongolia” https://gratanet.com/laravel-filemanager/files/3/Legal%20alert_Constitution_final.pdf

			заалт бүрийг хүснэгтлэн танилцуулжээ.
6	Принстоны Их сургуулийн доктор, социологич, Жулиан Дьеркес \Julian Dierkes\	“Монгол улс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталлаа” ⁸⁸	<p>Принстоны Их сургуулийн доктор, социологич мэргэжилтэй Жулиан Дьеркес нь 2005 оноос эхлэн Монгол улсын талаар дагнан судалсан Монголч судлаач болно. Тэрээр “Монгол Улс Үндсэн Хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталлаа” нийтлэлдээ Монгол Улсын Их Хурал нь 2019 оны 11 сарын 14-ний өдөр Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталсан тухай товч дурдаад ямар ямар агуулга бүхий нэмэлт өөрчлөлт орсон болохыг албан бус орчуулгаар судлан нийтэлжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Байгалийн нөөц – (1) байгалийн баялгийн ашиглалтыг төрийн урт хугацааны бодлогод тулгуурлан Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх үр өгөөжийг хүн амын амьдрах орчныг сайжруулах, тэгш хуваарилах; (2) байгалийн баялгийн ашиглалтын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг иргэд мэдэх эрхтэй; (3) стратегийн ач холбогдол бүхий ордуудыг олон нийтээр удирдах тухай нэмэлт өөрчлөлт - Улс төрийн намууд - (1) ардчилсан зарчмын дагуу бүтэцлэгдсэн, санхүүгийн хувьд ил тод байх; (2) улс төрийн намуудын санхүүжилтийг хуулиар зохицуулна [Улс төрийн намын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаас гадна улс төрийн намуудын санхүүжилтийг төрөөс санхүүжүүлнэ гэсэн зохицуулалт]. - Бодлогын залгамж чанар – (1) парламент бодлого (нийгмийн хөгжил, эдийн засаг)-ыг тодорхойлдог; (2) парламент санал

⁸⁸ Julian Dierkes by “Constitutional Amendments Adopted” article November 15, 2019, <https://blogs.ubc.ca/mongolia/2019/constitution-reform/>

			<p>болгож буй улсын төсвийг нэмэгдүүлэх боломжгүй; (3) урт хугацааны хөгжлийн бодлогод өөрчлөлт оруулах хязгаарлалт.</p> <ul style="list-style-type: none"> - Ард нийтийн санал асуулга явуулах зохицуулалт - УИХ-ын гишүүд тэдгээрийн хариуцлагатай холбоотой нэмэлт өөрчлөлт - Засгийн газар – (1) Ерөнхий сайд, Засгийн газрын дөрвөн албан тушаалтан УИХ-ын гишүүн байж болно; (2) Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдийг парламентаар хэлэлцүүлэхгүйгээр, ерөнхийлөгчтэй зөвшилцөхгүйгээр өөрчлөх; - Ерөнхийлөгч – (1) доод тал нь 50 настай; (2) нэг удаа, зургаан жилийн хугацаатай сонгогдох тухай заалт; - Шүүхийн ерөнхий хороо – (1) нийт 10 гишүүнтэй: 5 гишүүнийг шүүхийн мэргэжлийн хүмүүс томилно, 5 гишүүнийг нээлттэй өрсөлдүүлнэ; (2) зөвхөн дөрвөн жилийн хугацаатай ажиллах боломжтой байна; - Шүүхийн сахилгын хороо байгуулагдана - хороо нь шүүгчийг огцруулах, сахилгын арга хэмжээ авах эрхтэй болно; - Хотын статус – бүх аймгийн төвүүд, Дархан, Эрдэнэт хотууд хотын статустай болно. <p>Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дээрх байдлаар тайлбарлажээ.</p>
7	<p>Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч Иоганн Фюрман \Johann Fuhrmann\, Конрад-</p>	<p>Guest Post: Democracy in Danger? A Court Ruling with Serious</p>	<p>Тус нийтлэлд дараах санаануудыг тусгажээ. 2019 онд Монгол Улс хагас Ерөнхийлөгчийн засаглалыг парламентын засаглал руу шилжүүлэх Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах үндсэн хуульд хэд хэдэн нэмэлт, өөрчлөлт оруулах санал дэвшүүлсэн. Шинэ нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн албан</p>

	<p>Аденауэр-Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын бодлогын ахлах шинжээч Макс Дакстайн \Max Duckstein\</p>	<p>Implications for Mongolia's Future “Зочин: Ардчилал аюулд оров уу? Монголын ирээдүйд ноцтой үр дагавартай шүүхийн шийдвэр” нийтлэл⁸⁹</p>	<p>тушаалд гарсан хамгийн ноцтой өөрчлөлт нь 30.2-т зааснаар дөрвөн жилийн хугацаагаар улируулан сонгох бус зургаан жилийн бүрэн эрхийн хугацаагаар 1 удаа сонгох зохицуулалт байсан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 30.2 дах заалт нь 2025 оноос хүчин төгөлдөр болно гэж заасан байсан. Энэ нь Монгол Улсын 5 дахь Ерөнхийлөгч Х.Баттулга дахин нэр дэвших эрхтэй болох баталгаа байсан. Мөн нэмэлт, өөрчлөлтөөр Шүүхийн бие даасан байдал, шүүгчдийг улс төрчдийн талд шийдвэр гаргадаг асуудал зэргийг шийдэх заалтуудыг баталсан.</p>
<p>8</p>	<p>Питер Шаллер \Peter Schaller\</p>	<p>MONGOLIA'S CONSTITUTIONAL AMENDMENT 2020 - HARDLY ANY PROGRESS Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт - 2020 (Ямар ч ахиц гараагүй) нийтлэл⁹⁰</p>	<p>Энэхүү нийтлэлд 2020 оны 5 дугаар сараас хүчин төгөлдөр болсон Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг төслийг шүүмжлэх, ямар өөрчлөлт орсон талаар танилцуулж бичигджээ. Танилцуулга хэсэгт 2019 оны 11 сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан болохыг дурдаад “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн гурван эрх мэдлийн (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) хоорондын харилцааны тэнцвэргүй байдлыг бууруулж, улс орныг удирдах чадварыг бэхжүүлэх зорилготой байсан бөгөөд зарим нэг сайжруулалт гарсан ч өөрчлөлт нь тийм ч том биш. Эрх мэдэл хоорондын өрсөлдөөн, тэнцвэргүй байдал, тодорхой бус байдал байсаар байна” хэмээжээ. Цаашлаад “Үндсэн хууль нь төр, нийгмийн үндсэн шинж чанарыг тодорхойлдог ба Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх нь дан ганц танилцуулга, бичвэрийг унших бус 1989, 1990 оны Монголын улс төрийн эргэлт, сүүлийн 10 жилийн Монгол улсын нийгэм-эдийн засаг, улс төрийн хөгжлийг судлах</p>

⁸⁹ <https://www.kas.de/documents/268650/268699/Gastbeitrag+Mongolia+Focus.pdf/2c24f4ab-cd70-3967-9c25-9b048784c3da?version=1.0&t=1619098872904>

⁹⁰ <http://baabar.mn/article/mongolia-s-constitutional-amendments-2020>

			<p>шаардлага үүснэ. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр Монголын улс төрийн тогтолцооны дутагдлыг арилгасан гэж үзвэл эндүүрэл болно”. Нийтлэлийн бүтцийн нийтлэлч дараах байдлаар бэлтгэжээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Ардчилсан тогтолцооны гол шинж чанарууд: Хууль тогтоох (парламент), гүйцэтгэх (засгийн газар), шүүх (шүүх) нь бие биеэсээ хараат бус байдлын тухай. • Монгол Улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол асуудал: Энэ нь төрийн тогтолцоог аль чиглэлд илүү хөгжүүлэх ёстой вэ гэсэн асуудал юм. Ерөнхийлөгч давамгайлсан АНУ, Франц/ОХУ-ын нэгэн адил ерөнхийлөгчийн буюу хагас ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоо руу, эсвэл засгийн газрын тэргүүний хүчтэй байр суурьтай, парламентын өмнө хариуцлага хүлээдэг тууштай парламентын засаглалын тогтолцоо руу шилжих, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хязгаарлах, жишээлбэл, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын нэгэн адил зөвхөн төлөөлөх чиг үүрэгтэй байх уу зэрэг нь гол асуудал байсан. • Хуучин Үндсэн хуулийн шинж чанарууд: 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн голлох сул тал нь 20-29-р зүйл болох Монгол Улсын Төрийн байгуулал байсан. <p>Мөн цаашлаад “Улс төрийн үйл ажиллагааны доголдол”, “Үндсэн хуулийн бодит байдлын сөрөг тал”, “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт”, “Дүгнэлт ба хэтийн төлөв” зэрэг асуудлуудыг хөнджээ.</p> <ul style="list-style-type: none"> - Дүгнэлт хэсгээр “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг даган боловсруулагдах 40 гаруй хууль, тэдгээрийн хэрэгжилтээс шалтгаалан Үндсэн хууль хэр үр дүнтэй болохыг
--	--	--	---

			харж чадна.” гэж судлаач Питер Шаллер үзэж байна.
9	Niels Hegewisch /Friedrich-Ebert- Stiftung/	“Stabilität und Transparenz- Verfassungsreform in der Mongolei” ⁹¹	Тус нийтлэлийг тухай үеийн Фридрих-Эберт сангийн суурийн төлөөлөгч Нийлс Хэгевиш бичсэн бөгөөд Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2016 оны УИХ-д олонх болсон МАН-ын сонгуулийн гол амлалт байсан гэжээ. Монгол улс нь Парламентат ёс болон Ерөнхийлөгчийн хосолмол тогтолцоотой. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон УИХ-ын эрх мэдэл түүний хуваарилалт нь удаа дараа зөрчил гарч гацаа үүсгэж улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэсээр байсан. Монгол улсын Засгийн газрын ажиллах хугацаа дунджаар 2 жил хүрдэггүй. Эрх мэдлийн хуваарилалтын асуудлаас болж хөгжил удаан явагддаг. Харин Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаараа Парламентын олонхоос сонгогдсон Ерөнхий сайдын байр суурийг бэхжүүлж, эрд түмнээс сонгогдсон ерөнхийлөгчийг сулруулж байна. Гэхдээ тус нэмэлт, өөрчлөлт нь улс төрийн намаас ил тод байдлыг шаардсан, шүүх эрх мэдлийн салбарт илүү хяналт тавьж, нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоог өөрчилжээ.
10	Batmunkh Ts., Munkhjargal S., Prof. Dr. Sarantuya Ts., /Hanns-Seidel- Stiftung//	“Ringen um Stabilität” ⁹²	Сүүлийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд парламент 20 жилийн дараа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж эхэлсэн. 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн үндсэн өөрчлөлтүүд нь парламентын үндсэн дэг журам, илүү тогтвортой Засгийн газрыг бэхжүүлэхийн тулд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг илүү тодорхой хуваарилж, улс төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, улс орны байгалийн баялгаас олох орлогыг тэгш

⁹¹ <https://mongolia.fes.de/news/stabilitaet-transparenz-verfassungsreform-in-der-mongolei/>

⁹² <https://www.hss.de/news/detail/ringen-um-stabilitaet-news6404/>

			хуваарилахад чиглэж байна. Шүүхийн бие даасан байдал, аймаг хотын нутгийн өөрөө удирдах ёсыг мөн бэхжүүлжээ.
11	Montsame Mongolian New Agency “Монцамэ агентлаг”	“Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу нийгмийн гэрээний шинэчилсэн найруулга” мэдээ ⁹³	<p>Энэхүү мэдээнд 1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хуулийн батлагдах үеийн тоо баримт, түүний үе үеийн өөрчлөлтийн ач холбогдол, сул талыг цохон тэмдэглэжээ. 2008-2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг долоон удаа байгуулагдаж, 2011, 2012, 2015 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн ч хууль тогтоох төвшинд нэг ч удаа хэлэлцэгдээгүй. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан тэргүүтэй 63 гишүүн 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлснээр хуулийн төслийн талаар УИХ-ын чуулганы нэгдсэн болон байнгын хорооны 36 удаагийн хэлэлцүүлэг 105.9 цаг үргэлжилж, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг 2019 оны 11-р сарын 14-нд баталсан” хэмээн мэдээлэлжээ. Нийтлэл нь дараах хэсгүүдээс бүтэж Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар иргэдэд мэдээлэл хүргэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Баялаг ба Ирээдүй - УИХ-ын эрх ба хариуцлага - Ерөнхий сайдад олгосон эрх мэдэл ба тогтвортой Засгийн газар - Шүүхийн эрх мэдэл болон хараат бус байдал - Нутгийн удирдлагын эрх болон хотын статусын асуудал <p>Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол, түүний хавсралтаар батлагдах, шинэчлэн найруулах хувиар бүхий 40 гаруй хууль буйг мэдээлсэн байна.</p>

⁹³ <https://montsame.mn/en/read/227041>

ДҮГНЭЛТ

Монгол улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачид өөрсдийн байр суурийг илэрхийлсэн нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд гарган, уншигч олонд хүргэжээ. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлэлцэгдэж эхлэхээс ч өмнө салбар бүрд хэлэлцүүлэг, судалгааны ажил маш ихээр хийгдэж байсан. Нэмэлт, өөрчлөлт батлагдсаны дараагаар ч судалгаа, шинжилгээний ажил цөөрөөгүй. Улс төр судлалын хүрээнд улс төрийн нам, түүний санхүүжилт болон засгийн газрыг байгуулж, огцруулах асуудал үргэлж олны анхаарлыг татсан топ сэдэв байсаар ирсэн. Дээрх судалгааны хүснэгтээс харахад энэ удаад ч мөн хамгийн их судлагдсан, нийтлэгдсэн сэдвийн жагсаалтад уг сэдвүүд тэргүүлж байна. Харин эрх зүйн судалгааны агуулгын хүрээнд үндсэн хуулийн 6.2 дахь заалт илүү их хөндөгдсөн сэдэв байв. Мөн үүнээс гадна шүүхийн тогтолцоо, шүүхийн томилгоотой холбоотой зүйл, заалтууд нэлээдгүй их судлагдаж, судлаачид өөрсдийн байр суурийг илэрхийлжээ. Дотоодын эрдэмтэн судлаачид гадаадын сэтгүүлд үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нийтлэл, өгүүлэл, судалгааны бүтээлээ хүргэсэн бол мөн нөгөө талаас гадаад улсын судлаачид Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой судалгааг хийн, дүгнэлт, саналаа өгчээ. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гэдэг бол тухайн улсын хувьд, тухайн улсыг судалдаг судлаачдын хувьд, нягт харилцаа, холбоо бүхий бусад улс орны хувьд чухал үйл явдал байдаг билээ. Тиймээс Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд зөвхөн дээрх хүснэгтэд зааснаар хязгаарлагдахгүй бөгөөд цаашид ч мөн үргэлжилсээр байна гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль
- “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” дугаар 02, хавсралт

Ном, сурах бичиг:

- О.Машбат, Үндсэн хууль: Улс төр-эрх зүй, хянал-тэнцэл, 2015
- Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, 2019
- “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, “Эрх зүйн боловсрол академи” УБ, 2009
- “Үндсэн хуулиа ойлгохуй” Ц.Товуусүрэн, УБ, 2020

Өгүүлэл, илтгэл, судалгааны тайлан:

- “Хууль дээдлэх ёс” сэтгүүл
- “Шүүх эрх мэдэл” сэтгүүл
- П.Амаржаргал, “Парламентаас албан тушаалтныг сонгох тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл, шалтгаан”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2017
- Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа, УБ, 2017
- Г.Дугаржав, “Ерөнхий сайдыг томилох, Засгийн газар бүрдүүлэх үйл явцад Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн хэрэгжүүлж байгаа эрх, үүрэгт хийсэн шинжилгээ”, УБ, 2018
- “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” УБ, 2016
- Н.Отгонбаяр “Засгийн газрыг байгуулж, огцруулах, эрх зүйн зохицуулалт, төрийн бодлогын тогтвортой байдалд үзүүлэх нөлөө”, Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа, Конрад-Аденауэр сан, УБ, 2018
- Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ, УБ, 2015
- О.Мөнхсайхан, “Засгийн газрыг эмхлэн байгуулах ажиллагаа”, Төрийн байгуулал судлал сэтгүүл, Конрад Аденауэр сан, УБ, 2018
- “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ” УБ, 2016
- Д.Бумдарь, Я.Төгөлдөр, “Бодлогын намыг төлөвшүүлэх нь”, Нээлттэй Нийгэм Форум, УБ, 2022 он
- Д.Бумдарь, Я.Төгөлдөр, “Эвлэлдэн нэгдэх эрх ба улс төрийн намын хатуу гишүүнчлэл” бодлогын хэлэлцүүлэг, Нээлттэй Нийгэм Форум, УБ, 2022 он
- Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал”, бодлогын хэлэлцүүлэг, Нээлттэй Нийгэм Форум, ШУТИС, УБ хот, 2021 он
- Э.Гэрэлт-Од, “Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь”, Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, УБ, 2020
- “Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт”, Нээлттэй Нийгэм Форум болон Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (АСДҮОУХ), УБ, 2020 он,
- Г.Чулуунбаатар, Ш.Батсүх, Б.Ганцоож “МОНГОЛЫН АРДЧИЛАЛ: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж”, Төлөөллийн ардчиллын үндсэн сорилтууд, Конрад-Аденауэр сан, УБ, 2021

- Конрад-Аденауэр сан, “Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа” /судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/
- Б.Эрдэнэдалай, “Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтийн тулгамдсан асуудал, цаашдын хандлага”, Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан асуудал, цаашдын хандлага судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж, Конрад Аденауэр сан, УБ, 2021
- Б.Улсболд: Монгол Улсын Үндсэн Хууль дахь намын дотоод ардчиллын зохицуулалттай холбогдох эрх зүйн шинэтгэл: Харьцуулсан судалгаа (legaldata.mn)
- Д.Баяр: Монгол Улсын Үндсэн Хуулийн 6.2.- ийн Нэмэлт, Өөрчлөлт ба Хуулийн “Романтизм” (legaldata.mn)
- О.Мөнхсайхан: Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал: газрын хэвлийн баялаг ашиглахад баримтлах зарчмууд (legaldata.mn)
- Д.Ганхүрэл, Д.Сүнжид, А.Түвшинтөгс, Б.Гүнбилэг, Н.Лхамцэрэн: Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн хоёр дахь хэсгийн үзэл баримтлалыг тодруулах нь (legaldata.mn)
- С.Асланбек: Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт орсон нэмэлт, өөрчлөлтийн зарим нэр томъёог хүний эрхийн үүднээс тайлбарлах нь (legaldata.mn)
- С.Асланбек: Монгол улсын үндсэн хууль дахь үндэсний баялгийн сангийн тухай зохицуулалт ба олон улсын туршлага (legaldata.mn)
- Р.Лхагвабаяр: Байгалийн баялаг ашиглалттай холбоотой иргэний мэдэх эрх ба эрх зүйн шинэтгэл (legaldata.mn)
- О.Хишигмөнх Б.Досжан: Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт: Ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах зарчмыг хэрэгжүүлсэн эсэх асуудал (legaldata.mn)
- Г.Оюундарь: Нам байгуулах шалгуурыг Монгол улсын үндсэн хуулийн нэмэлтээр бүрдүүлсэн нь хүний эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан эсэх талаарх судалгаа (legaldata.mn)
- Г.Давааням: Төрийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт (legaldata.mn)
- В.Оюумаа: Төрийн өмчийн тухай эргэцүүлэхүй (legaldata.mn)
- Нээлттэй Нийгэм Форум: Улсын дээд шүүхийн чиг үүргийн талаарх харьцуулсан шинжилгээ (legaldata.mn)
- П.Баттулга: Монгол улсын шүүхийн томилгооны системийг боловсронгуй болгох нь/ Strengthening the judicial appointment system of Mongolia (legaldata.mn)
- П.Баттулга: Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг Үндсэн хуулиар тодорхойлсны ач холбогдол юу вэ? (legaldata.mn)
- Б.Мягмарсүрэн: Монгол улсын үндсэн хууль дахь ерөнхий сайдад итгэл хүлээлгэх зохицуулалт ба хууль тогтоох байгууллагын оролцоог хязгаарлах механизмын зарим асуудал (legaldata.mn)
- Ц.Цогт: ҮХНӨ: Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг юу вэ? (legaldata.mn)
- Л.Энхтайван: Гүйцэтгэх эрх мэдэл ба шүүх эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн зарим асуудалд (Захиргааны байгууллагын сонгох боломжийн хүрээнд) (legaldata.mn)
- Г.Цэрэндэжид: Шүүхийн сахилгын хороо, түүний бүрэлдэхүүн ба шүүгчийн хараат бус байдал (legaldata.mn)
- Р.Оюундэлгэр: Шүүхийн тогтолцоо дахь хууч хамаарал буюу шүүхийн нутаг дэвсгэрийн зарчмын хэв маяг, түүнийг халж үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх нь (legaldata.mn)
- Б.Лхагважаргал, Х.Норовсүрэн: Нутгийн өөрөө удирдах байгууллагын хараат бус, бие даан шийдвэр гаргах эрхийг үндсэн хуулиар хамгаалах нь (legaldata.mn)
- З.Сийлэгмаа: Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт ба эрх зүйн шинэчлэл (legaldata.mn)

- Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх, С.Батбаяр: Шүүхийн тогтолцоо: Тойргийн болон дагнасан шүүх (legaldata.mn)
- Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимид, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ, 2020

Цахим эх сурвалж:

- Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан www.legaldata.mn
- Монгол Улсын Засгийн газрын цахим сан <https://mongolia.gov.mn/>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn
- “Засгийн газрын тогтвортой байдлыг хангах нь- Конструктив механизм нь Монголд тохиромжтой эсэх нь” мэтгэлцээн, 2017
- О.Мөнхсайхан, “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн амин сүнс (ЗГ,Шүүх) долоохон санал дутсанаас үгүй болох уу” нийтлэл, 2019 он <https://ikon.mn/opinion/1nzc>
- Б.Чимид, Ардчиллын аман түүх, <https://www.youtube.com/watch?v=ZbjpmWLO7M0>
- О.Мөнхсайхан, Гурван парламент дамжсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталлаа, 2019, <https://ikon.mn/n/1q5f>

Гадаад эх сурвалж:

- Munkhsaikhan Odonkhuu “Mongolia’s Long, Participatory Route to Constitutional Reforms”, [Mongolia's Long, Participatory Route to Constitutional Reforms | ConstitutionNet](http://Mongolia's%20Long,%20Participatory%20Route%20to%20Constitutional%20Reforms%20|%20ConstitutionNet)
- Bolormaa Volodya “Mongolia: The Amendment On Constitution Of Mongolia” article by GRATA International
[The Amendment On Constitution Of Mongolia - Government, Public Sector,](http://The%20Amendment%20On%20Constitution%20Of%20Mongolia%20-%20Government,%20Public%20Sector,%20)
<https://verfassungsblog.de/the-price-of-limiting-power/>
- GRATA International “Legal update: The Amendment on Constitution of Mongolia”
[https://gratanet.com/laravel-filemanager/files/3/Legal%20alert Constitution final.pdf](https://gratanet.com/laravel-filemanager/files/3/Legal%20alert%20Constitution%20final.pdf)
- Julian Dierkes by “Constitutional Amendments Adopted” article November 15, 2019,
<https://blogs.ubc.ca/mongolia/2019/constitution-reform/>
<https://www.kas.de/documents/268650/268699/Gastbeitrag+Mongolia+Focus.pdf/2c24f4ab-ed70-3967-9c25-9b048784c3da?version=1.0&t=1619098872904>
- https://www.google.com/url?client=internal-element-cse&cx=016364595556873131513:lg-p43v3tam&q=https://www.mn.undp.org/content/dam/mongolia/Publications/2019%2520annual%2520report_SRBM_eng.pdf&sa=U&ved=2ahUKEwj71NW7ksj2AhXdy4sBHerxCPUQFnoECAAAQ&usg=AOvVaw37QzLfwVPk3yXHMRNd3zd9
- <http://baabar.mn/article/mongolia-s-constitutional-amendments-2020>
- <https://mongolia.fes.de/news/stabilitaet-transparenz-verfassungsreform-in-der-mongolei/>
- <https://www.kas.de/mn/web/mongolei/laenderberichte/detail/-/content/die-juengste-mongolische-justizreform>
- <https://montsame.mn/en/read/227041>
- <https://www.hss.de/news/detail/ringen-um-stabilitaet-news6404/>

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Ерөнхий сайдын томилгоо	8
Хүснэгт 2. 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 27.6	8
Хүснэгт 3. Үндсэн хууль батлагдсанаас хойш байгуулагдсан засгийн газрууд	11
Хүснэгт 4. Засгийн газрын үндсэн бүтцийн өөрчлөлт 1992-2016 он	11
Хүснэгт 5. Засгийн газрын тогтвортой байдал: Ерөнхий сайдын бүрэн эрхийн хугацааны дундаж	13
Хүснэгт 6. Дэлхийн улс орнуудын ерөнхий сайдыг огцруулах арга замын харьцуулалт	16
Хүснэгт 7. Парламентын гишүүн засгийн газрын гишүүний ажил, албан тушаал давхар эрхлэхийг зөвшөөрдөг зарим орны судалгаа	18
Хүснэгт 8. Парламентын гишүүн болон засгийн газрын гишүүний албан тушаалыг давхар эрхлэхийг хориглосон зарим улс орнууд	19
Хүснэгт 9. Улс орнуудад засгийн газрын тэргүүн болон гишүүдийг огцруулах субъект	21
Хүснэгт 10. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт	21
Хүснэгт 11. Үндсэн хуулийн 44.1 болон 44.2. дахь хэсгийн нэмэлт, өөрчлөлт болон өмнөх зохицуулалтын харьцуулалт	22
Хүснэгт 12. Үндсэн хуулийн 43.1 болон 43.2 дахь хэсгийн нэмэлт, өөрчлөлт болон өмнөх зохицуулалтын харьцуулалт	24
Хүснэгт 13. Үндсэн хуулийн 39.1 дэх хэсгийн нэмэлт, өөрчлөлт болон өмнөх зохицуулалтын харьцуулалт.....	25
Хүснэгт 14. Шадар сайд болон засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга.....	26
Хүснэгт 15. Монгол улсын засгийн газрын бүрэлдэхүүн	27
Хүснэгт 16: Дотоодын сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлийн жагсаалт	29
Хүснэгт 17:Гадаадын сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлийн жагсаалт	63